

“ТАВАНТОЛГОЙ-МАНЛАЙ-ХАНГИ ЧИГЛЭЛИЙН ХҮНД
ДААЦЫН ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ БАЙГУУЛАХ
ТӨСӨЛ”-ИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН

ХЯНАСАН :

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН / _____ / (П. ШИНЭЦЭЦЭГ)

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН :

“ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

“ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС” ХХК-ИЙН БО-НЫ
МЭРГЭЖИЛТЭН



(ЛАЙ ЖЕНЬ БАО)

(Б. ОТГОНБААТАР)

Улаанбаатар хот



TAKHILT KHAIKHAN TRANS
LLC

ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС ХХК

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо,

Их Монгол Улсын гудамж,

Монвис Бюлдиг, 6-р давхар

Утас: + (976) 7720-0990, 88109158

Email: admin@tkl.mn

2023.05.03 № 23/154
танай _____ ны № _____ д

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАРТ

Тайлан хүргүүлэх тухай

Манай компани Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газартай байгуулсан концессийн гэрээний дагуу "Тавантолгой – Манлай – Ханги" чиглэлийн хатуу хучилттай 477 км авто зам барих төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2021 оны 2-р сарын 08-ны өдрийн 2019/J207 дугаар бүхий төслийн Байгаль орчны нарийвчилсан байдлын үнэлгээнд суурилан боловсруулсан 2022 оны байгаль орчны менежмент төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот бүхий журмын дагуу боловсруулан, дахин хянуулахаар хүргүүлж байна.

Иймд 2022 оны байгаль орчны хэрэгжилтийг хянан шалгаж, бидний ажилд дэмжлэг үзүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ЛАЙ ЖЭНЬБАО

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ,
НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХҮЛЭЭН АВСАН
АЖЛЫН ХЭСГИЙН ДҮГНЭЛТ**

2023-05-15

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу Цогтцэций, Манлай, Ханбогд сумдын нутагт Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн хүнд даацын хатуу хучилттай авто зам байгуулах төслийн “Тахилт хайрхан транс ХХК”-ний 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн нэмэлт тайлан, биелэлтийг газар дээр нь үзэж дараах дүгнэлтийг гаргав.

**ТАВАНТОЛГОЙ-МАНЛАЙ-ХАНГИ ЧИГЛЭЛИЙН ХҮНД ДААЦЫН ХАТУУ ХУЧИЛТТАЙ
АВТО ЗАМ БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ ХУУДАС /нэмэлт/**

№	Бүрэлдэхүүн хэсгүүд	Биелэлтийн оноо	Тайлбар, үндэслэл
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт /20/	18	<p>Нийт 19 ажил төлөвлөснөөс агаар орчныг сайжруулах зорилгоор 6 ажил төлөвлөж 90%, хөрс хамгаалах зорилгоор 3 ажил төлөвлөж 90%, усан орчинг хамгаалах зорилгоор 6 ажил төлөвлөж 93%, амьтан хамгаалах чиглэлээр 4 ажил төлөвлөж 87.5%-тай хэрэгжүүлсэн байна.</p> <p>Нэмэлт тайлангаар мал амьтны гарц гарам байгуулах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран байршлыг тогтоон, зураг төсөвт тусгасан, зэрлэг амьтдад зориулсан автомат ажиллагаатай уст цэг байгуулах ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байгаа, кемпүүдийн хог хаягдлыг цэвэрлэсэн, сургалт зохион байгуулсан, хог түр хадгалах цэгтэй болсон, Манлай сумын Засаг даргын захирамжаар эрүүл ахуйн бүс тогтоосон, ус ашигласны төлбөр төлж, гэрээ дүгнэсэн, түр замын засвар үйлчилгээ, усалгаа арчилгааг хийж эхэлсэн, техникийн засвар үйлчилгээ хийх талбай бэлтгэсэн байна.</p> <p>Нийт хэрэгжилт 90.1%</p>
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт /30/	27	<p>Нийт 5 ажил төлөвлөсөн. Нэмэлт тайлангаар түр кемпүүдийн хог хаягдлыг цэвэрлэсэн. Ашиглалт дууссан ТГАМ-ын Цогтцэций сумын нутагт байрлах зөвшөөрөлтэй 2, зөвшөөрөлгүй 1 карьерын нөхөн сэргээлтийг стандарт шаардлагын дагуу бүрэн хийж хүлээлгэн өгсөн. Мөн ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу Манлай сумын нутагт</p>

			<p>эдвэрч эзэнгүй орхигдсон 5 га техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн байна. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийх ажлын төлөвлөгөө боловсруулаагүй, 5 кемп бүхий газарт 92 ширхэг улиас, хайлаас тарьсан.</p> <p>Нийт хэрэгжилт 90%</p>
3	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт /5/	5	Төлөвлөгдөөгүй
4	Осол эрдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт /15/	13.8	<p>Нийт 4 ажил төлөвлөж, 3 ажлыг 100%, Нэмэлт тайлангаар шатах тослох материал асгарахаас хамгаалах, асгарсан тохиолдолд нэвчих шингээх материал байрлуулах, бохирдсон хөрснийг саармагжуулах талбайг бэлтгэх ажлыг хийж эхлүүлсэн /70%/. Засварын хэсгийг хөрс бохирдохоос хамгаалж тусгаарлах хучилт хийсэн. Асгаралтын үеийн зааварчилгаа боловсруулж, ажилчиддаа танилцуулсан байна.</p> <p>Нийт хэрэгжилт 92.5%</p>
5	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт /10/	9.5	<p>Нийт 10 ажил төлөвлөж 32 хувьтай хэрэгжүүлсэн байсан ба нэмэлт тайлангаар хог хаягдлыг төрөлжүүлэн ангилан ялгах, хогийн сав байрлуулах, орчны хог цуглуулах, хог хаягдлын гэрээ байгуулах, тайлан мэдээ /БОХ/-г орон нутагт хүргүүлэх, бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулах, сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг хийсэн байна. Сумдад хог хаягдлын ангилан ялгалтын сав байрлуулахаар захиалсан, хөрс бохирдуулагч 4 жорлонг татан буулгаж ариутгал халдваргүйтгэл хийсэн.</p> <p>Нийт хэрэгжилт 95%</p>
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт /10/	10	<p>Нийт 5 ажил төлөвлөж нэмэлт тайлангаар бүрэн хэрэгжүүлсэн.</p> <p>Нийт хэрэгжилт 100%</p>
7	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт /5/	4.25	<p>Нийт 4 ажил төлөвлөж, нэмэлт тайлангаар хөв цөөрөм байгуулах ажлыг усны мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байгаа, нийт ажилчдад байгаль хамгаалах, хог хаягдал хаяхгүй байх, асгаралтаас хамгаалах сургалт хийж, бүх нийтийн цэвэрлэгээ хийсэн байна. Цогтцэций суманд байгаль хамгаалах тэмдэглэлт өдрийг зохион байгуулаагүй.</p> <p>Нийт хэрэгжилт 85%</p>
8	Аймаг сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон	3.5	<p>Нийт 4 ажил төлөвлөж, олон нийтэд тайлагнах заалтыг Ханбогд, Цогтцэций сумдад хэрэгжүүлээгүй, нэмэлт тайлангаар сумдын ЗДТГ, Байгаль хамгаалагч, БОХУБ</p>

нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт /5/		нарт жилийн эцсийн тайлан болон БОХ тайланг хүргүүлсэн. Нийт хэрэгжилт 70%
Дүн (арифметик дундаж)	91.5	Хангалттай


Тахилт хайрхан транс ХХК нь 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан 8-н бүрэлдэхүүн хэсэг ажлын хэрэгжилтийг нэмэлт тайлангаар 91.5 оноотой хангалттай хэрэгжүүлсэн гэж дүгнэв.

Комиссын дарга



Х.Отгонмөнх
/БОАЖ-ын газрын дарга/

Гишүүд



Т.Бадамцэцэг
/Зүүн бүс хариуцсан БОХУБайцаагч/




Ф.Мангуйвдорж
/Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны төлөөлөл/



Ц.Мөнхдэлгэр
/Цогтэрший сумын Сийрс багийн ИТХ-ын дарга, иргэний төлөөлөл/



Л.Энхцэцэг
/Цогтэрший сумын Сийрст багийн Засаг дарга, иргэний төлөөлөл/



Б.Жаргал
/Цогтэрший сумын Билгэх багийн Засаг дарга, иргэний төлөөлөл/



М.Цэрэнсодном
/Манлай сумын нутаг дэвсгэр хариуцсан Байгаль хамгаалагч/



А.Ганхуяг
/Манлай сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч/



М.Дондов
/Манлай сумын Өгөөмөр багийн Засаг дарга, иргэний төлөөлөл/



Ж.Эрдэнэбаяр
/Манлай сумын Жаргалант багийн Засаг дарга, иргэний төлөөлөл/

Нарийн бичгийн дарга



Б.Оргилмаа
/БО-ны газар, газрын хэвлий түүний баялагийн ашиглалт, нөхөн сэргээлт, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн/

Хүлээн зөвшөөрсөн
Тахилт хайрхан транс
ХХК-ний Гүйцэтгэх
захирал



Лай Жэнь Бао



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: (976) 7052 2663, факс: (02-522) 4-27-26
Цахим шуудан: Dgaboajg@do.mnc.gov.mn
Цахим хаяг: www.do.mnc.gov.mn

2023.01.30 № 41

танай _____-ны № _____-т

ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС ХХК-ИЙН
ЗАХИРАЛ ЛАЙ ЖЭНЬ БАО ТАНАА

**Дүгнэх хуудас болон чиглэл
хүргүүлэх тухай**

Танай хэрэгжүүлж буй хүнд даацын авто зам байгуулах төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт **90.0 хувьтай** үнэлэгдсэн дүгнэх хуудсыг хүргүүллээ.

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх асуудлыг чиглэл болгож байна.

1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төслийн онцлогт тохируулан бодитой төлөвлөж, сөрөг нөлөөллийг бууруулахад анхаарч, үр дүнг тоо баримттай тайлагнах
2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ны 58 дугаар зарлигийн дагуу "Тэр бум мод тарих" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд идэвх санаачлагатай оролцож тайлан мэдээ ирүүлэх
3. Өнгөрсөн онуудад ашигласан карьеруудын техник болон биологийн нөхөн сэргээлтийг хийж, аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт хүлээлгэн өгөх
4. Карьерийн нөхөн сэргээлтэд нутгийн унаган ургамалыг тарималжуулахад анхаарах
5. Нөхөн сэргээлт хийсэн талбайг тэмдэгжүүлж, зургийг 1:1000-1:2000 хураангуйлалтай, газарзүйн мэдээллийн системийн зургийн *.shp өргөтгөлтэй файл, баталгаажуулан авсан фото зургийг тайланд хавсаргаж ирүүлэх
6. Карьер болон барилга байгууламж барихаар төлөвлөж ухсан хоосон нүхэнд мал амьтан унаж бэртэхээс сэргийлж хашаажуулах
7. Авто замын трассын дагуу өртөж буй заган ойн хохирлын үнэлгээг тооцуулах
8. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд заг модыг үрслүүлж тариалах
9. Зэрлэг амьтны усан хангамжийг сайжруулахад зориулж мэдрэгчтэй худаг гарган камержуулах
10. Хууль бус ангийн талаарх үйл ажиллагааны мэдээллийг холбогдох газруудад шуурхай мэдээлж бүртгэлд авч ажиллах

442320030

11. Тээврийн жолооч нарын үүрэг хариуцлагыг сайжруулахад анхаарах /ил задгай хог хаях, маршрутын бус замаар тээвэр хийх/
12. Орчны хяналт шинжилгээг тогтмолжуулан хяналт тавин жил жилээр харьцуулан дүн шинжилгээг аймгийн УЦУОШТ-ийн лабораториар бүрэн хийлгэх, сорилын дүнд дүгнэлт гаргуулах
13. Стандартаас давсан үзүүлэлт болон зам барилга, бүтээн байгуулалт, тээвэрлэлтээс үүсч буй тоосны нөлөөллийг хянах, бууруулах арга хэмжээ авч төлөвлөн хэрэгжүүлэх
14. Хатанбулаг сумын нутагт байрлах 4,5,6 дугаар лотуудын кемпийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, дахин ашиглах цэгт өгөх
15. Трассын зам дагуух хог хаягдлыг тогтмол цэвэрлэж хэвших
16. Тосоор бохирдсон хөрсийг цэвэрлэж саармагжуулах арга хэмжээг авах
17. Авто засвар болон авто зогсоолын талбайг тос нэвчүүлэхгүй байхаар хайрган буюу бетонон хучилттай болгох
18. Аюултай хог хаягдлын бүртгэлийн дугаар авах
19. Аюултай хог хаягдлыг хуулийн хугацаанд хадгалах, хуулийн хугацаа өнгөрсөн тохиолдолд эрх бүхий байгууллагад шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах
20. Зам байгуулалтын үед шингэн хог хаягдлын зориулалтын цэгийг байгуулж ашиглах
21. Нүхэн жорлон MNS5924:2015 Нүхэн жорлон угаадасны нүх техникийн шаардлагыг хангаж ажиллах
22. Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, барилга хот байгуулалтын сайдын хамтарсан 2015 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/230/127 тоот тушаалаар баталсан "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн хамгаалалтын эрүүл ахуйн дэглэмийг мөрдөх журам"-ын дагуу худаг, уст цэгүүдэд хамгаалалтын бүс тогтоох
23. Монгол Улсын MNS4943:2015. Усны чанар, хаягдал усны стандартыг мөрдөж ажиллах
24. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 04 дугаар сарын 05-ны өдрийн А/82/128 дугаар хамтарсан тушаал "Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах" журмыг мөрдөж ажиллах
25. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-156 тоот тушаалаар баталсан "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-ын хэрэгжилтийг ханган ажиллах
26. Ашиглалтын худгуудын тоолуурыг шугам хоолойтой холбох
27. Зөвшөөрөлгүй цооног гарган ус авч ашиглахгүй байх
28. Ашиглахгүй болсон худгийн цооногийг битүүмжилж суманд хүлээлгэж өгөх
29. Унд ахуй болон технологийн усыг ашиглахдаа дүгнэлтэд заасан эх үүсвэрээс авч ашиглах

30. БОАЖС-ын 2019 оны 09-р сарын 19-ны А/527 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны статистик мэдээллийн маягтаар ус, хог болон бусад мэдээллийг сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэнд гаргаж өгч байх
31. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10¹ 1-д заасны дагуу Байгаль орчны аудит хийлгэн аудитын зөвлөмжийн биелэлтийг заасан хугацаанд ирүүлэх, дотоод хяналтыг сайжруулахад анхаарах
32. Батлагдсан зураг төсвийн дагуу гүйцэтгэж байгаа ажлыг менежментийн төлөвлөгөөнд оруулахгүй байх
33. БОАЖС-ын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу дутуу ирүүлсэн хавсралт болон 2021 онд өгсөн чиглэлийн дагуу биелэлтийг гаргаж ирүүлнэ үү.

ДАРГЫН ҮҮРГИЙН ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Н.ОТГОНБАЯР

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХАТАНБУЛАГ СУМЫН НУТАГТ ОРШИХ
"ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС" ХХК-ИЙН АВТОЗАМ БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН
2022 ОНЫ БОМТ-НИЙ БИЕЛЭЛТИЙН ДҮГНЭХ ХУУДАС**

Дугаар 2022/12

Төсөл хэрэгжүүлэгч ААН-ийн нэр: ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС" ХХК

Төслийн байршил: Дорноговь аймаг, Хатанбулаг сум

Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 6284655

Огноо: 2023.01.27

№	Комиссын гишүүдын нэр	Авбал зохих оноо	Нийт оноо	Дундаж	Үндэслэл, шаардлага
	Бүрэлдэхүүн хэсэг				
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	20	89.7	17.9	
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	30	134.6	26.9	
3	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	5	25	5	
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	15	70.7	14.1	
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	10	44.4	8.9	
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	10	41.7	8.3	
7	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	5	22.9	4.6	
8	Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах, төлөвлөгөөний биелэлт	5	21.4	4.3	
9	Эцсийн дүн	100	450.4	90.0	

Дүгнэлт: БОАЖС-ын 2019 оны 10-р сарын 29-ны А-618 тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу

"ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС" ХХК-ийн Хүнд даацын авто зам байгуулах 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг 90.0 хувьтай дүгнэв.

ДҮГНЭСЭН:

Комиссын дарга:		Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Отгонбаяр
Нарийн бичгийн дарга:		Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын уул уурхай, үнэлгээний мэргэжилтэн Д.Болормаа
Гишүүд:		Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын усны мэргэжилтэн Ш.Амгалансайхан
		Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч Э.Анхбаяр
		Галба-Өөш Долоодын Говийн Сав газрын захиргааны усны барилга байгууламж, үйлдвэр хөдөө аж ахуйн ус ашиглалтын мэргэжилтэн Э.Жанчивдорж

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:

"ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС ХХК-ИЙН ХАБЗАБО-НЫ ХЭЛТСИЙН МЕНЕЖЕР"  С.САРАНХҮҮ

20 23 оны 03 сарын 20 өдөр

АГУУЛГА

НЭГ ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛАГА	3
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл.....	3
1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	4
1.3 Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, талбайн байршил	4
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	5
2.1 Аймгуудын байгаль орчин, нийгэм эдийн засгийн ерөнхий мэдээлэл	5
2.2 Сумдуудын байгаль орчин, нийгэм эдийн засгийн ерөнхий мэдээлэл....	7
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
3.1 Байгаль орчны шууд ба шууд бус сөрөг нөлөөлөл	8
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	9
4.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт.....	9
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	11
5.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	11
5.1.1 Авто зам барих явцад ашиглаж буй тоног төхөөрөмжийн хурдыг хязгаарлах	14
5.1.2 Түр замын арчилгаа засвар, сайжруулалт хийж хяналт тавих	18
5.1.3 Түр замаар тээвэр хийж буй тухайн компанийн удирдлагуудад үүрэг өгөх.....	21
5.1.4 Тоосжилтыг бууруулахын тулд усалгаа хийж агаар орчныг чийгшүүлэх.....	23
5.1.5 Машин тоног төхөөрөмжинд тогтмол хяналт тавих.....	23
5.2 Хөрс ургамалан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	25
5.2.1 Олон салаа зам үүсгэхгүй байх, ажилчдын дотоод журам, ХАБ-н зааварчилгааг сануулах мэдээллэх	26
5.2.2 Шимт хөрс хуулах нөхөн сэргээлтэд туслан гүйцэтгэгч компаниудад хяналт тавих	26
5.2.3 Техникийн засвар үйлчилгээг хөрсөнд бохирдол үүсгэхгүйгээр хийх	28
5.2.4 Нэн ховор, ховор ургамал хууль бусаар түүж бэлтгэхтэй холбоотой постер хийх	28
5.3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	30

5.3.1 Төслийг хэрэгжүүлэх явцад ашиглах ус ашиглах тухайн жилийн дүгнэлтийг холбогдох газраар гаргуулах	32
5.3.2 Усны эх үүсвэр дээр суурилуулсан тоолуурын эвдрэл гэмтэлд хяналт тавьж ажиллах.....	33
5.3.3 Орон нутагтай усны гэрээ байгуулж төлбөр төлж ажиллах	34
5.3.4 Худаг уст цэгүүдэд хамгаалалтын бүс тогтоох.....	36
5.3.5 Үерийн урсац өнгөрөөх шугам хоолойг зураг төслийн дагуу хийж гүйцэтгэх.....	37
5.3.6 Ус өнгөрүүлэх шугам хоолойг малчдын гар худаг, булаг шандаас хол хийх	38
5.4 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	40
5.4.1 Мал амьтны гарцыг замын зураг төсөлд зурагдсаны дагуу хийж гүйцэтгэх.....	42
5.4.2 Зэрлэг амьтны судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж гүйцэтгэх.....	47
5.4.3 Биологийн олон янз байдлыг хамгаалах ажлын хүрээнд зэрлэг амьтадад зориулсан автомат ажиллагаатай уст цэгийг бий болгож хяналт мониторинг хийх камер суурилуулах.....	49
5.4.4 Биологийн олон янз байдлыг хамгаалах ажлын хүрээнд ан амьтныг хууль бусаар агнахтай холбоотой постер хийх.....	49
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	51
6.1.1 Техникийн нөхөн сэргээлт.....	53
6.1.2 Техникийн нөхөн сэргээлт.....	58
6.1.3 Тэрбум мод үндэсний хөдөлгөөн.....	60
ДОЛОО. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	62
НАЙМ. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	62
8.1.1 Шатах тослох материал хөрсөнд асгарах хөрс бохирдох улмаар усан орчинд нөлөөлөхөөс сэргийлэх.....	64
8.1.2 Тоосжилт ихсэж ажилчдын эрүүл мэнд оршин суугчдад нөлөөлөхөөс сэргийлэх.....	65
8.1.3 Ажилчид ан амьтан, ургамалд хор хохирол учруулахаас сэргийлэх.....	65
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	67
9.1.1 Хог хаягдлыг ангилан ялгах	70
9.1.2 Орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулан ажиллах	72
9.1.3 Үйл ажиллагаа явуулж буй газар нутгийн орчимд бүх нийтийн цэвэрлэгээг тогтмол зохион байгуулах	79

9.1.4 Сумын байгаль хамгаалагчтай хамтран хог хаягдлын ангилан ялгалтын сав байршуулах, сургалт зохион байгуулах.....	81
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ	85
10.1.1 Агаарын чанарын мониторингийн судалгааны нэгтгэсэн үр дүн ...	86
АРВАН НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	92
11.1.1 Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг сум орон нутгийн байгаль хамгаалагчтай хамтран зохион байгуулах.....	93
АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ	97

НЭГ ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛАГА

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

Концессын тухай хуулийн 6.2.12, Улсын Их Хурлын 2018 оны “Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 73 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-ын 20 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай, концессын

гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай” 238 дугаар тогтоолуудыг үндэслэн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгой нүүрсний уурхайгаас, Ханги боомт хүртэлх замыг хүнд даацын хатуу хучилттай авто замыг барьж байгуулна.

Уг төслийг Засгийн газрын тохируулагч агентлаг “ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР” захиалж концесс эзэмшигчээр манай байгууллага буюу “Тахилт хайрхан транс” ХХК ажиллаж байна.

Уг төслийн хүрээнд 1500 ажлын байр бий болох урьдчилсан тооцоололтой, автозам барилга угсралт 2,5жилийн хугацаанд хийж гүйцэтгэх ба уг замаар нүүрс тээвэрлэх хүчин чадал 22-25сая.тн/жилд авто зам эзэмших концессын гэрээ 27 жил байна. Зам ашиглалтанд орсноор 2500 нүүрс тээврийн жолооч нарын ажлын байр бий болно.


1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төслийн захиалагч:	“Засгийн газрын тохируулагч агентлаг ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР”
Концесс эзэмшигч:	“Тахилт Хайрхан Транс” ХХК
Төслийн ерөнхий гүйцэтгэгч:	“Ти Ти Си энд Ти” ХХК
Зураг төсөл зохиогч:	“Эй энд Би инженеринг” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011730029
Регистрийн дугаар:	6284655
Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Их Монгол улс, Моннис бьюлдинг, 6 давхар
Утас:	+(976) 88113610

1.3 Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, талбайн байршил

Төслийн автозамын эхлэл нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумд байрлах Эрдэнэставан толгойн нүүрсний ордын ачих талбайгаас эхэлж төгсгөл нь Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ханги боомтын ачаа тээврийн орцтой нийлж дуусна. Төлөвлөж буй автозамын трасс нь Өмнөговь аймгийн Манлай сумын баруун урдуур 12км орчим, Ханбогд сумын хойгуур 60 км орчим, Дорноговь аймгийн Хатанбулаг сумын баруун хойд талаар 7 км зайтай ба Өмнөговь аймгийн Цогтцэций, Манлай, Дорноговь аймгийн Хатанбулаг сумдын нийт 8 багийн нутаг дэвсгэрийг хэсэгчлэн дайран өнгөрөх 478,4 км урт зам тавигдах бөгөөд автозамын бүтээн байгуулалтыг 6 хэсэг буюу LOT болгон хуваасан.

Хэсэг д/д	Хоорондын зай км	Нийт зай км
Lot-1	11.1км – 86.6км	75.5км
Lot-2	86.6км – 187.73км	101.13км
Lot-3	187.73км – 261.51км	73.78км
Lot-4	261.51км – 355.51км	94.00км
Lot-5	355.51км – 431.51км	76.00км
Lot-6	431.51км – 479.01км	47.50км



Зураг 1. “Тавантолгой-Манлай-Ханги” чиглэлийн хүнд даацын авто замын төслийн зураг

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Аймгуудын байгаль орчин, нийгэм эдийн засгийн ерөнхий мэдээлэл

Өмнөговь аймаг : Өмнөговь аймаг нь 165,0 мянган хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй, 15 сум, 59 багтай. Аймгийн төв нь Даланзадгад хот. Өмнөговь аймаг нь Монгол улсын хамгийн өмнөд хэсэгт оршдог бөгөөд урд талаараа БНХАУ-тай, баруун

талаараа Баянхонгор, баруун хойд хэсгээр Өвөрхангай, хойд талаараа Дундговь, зүүн талаараа Дорноговь аймгуудтай тус тус хиллэн оршино. Аймгийн төв Даланзадгад хот нь Улаанбаатар хотоос 560 км зайтай.

Газарын гадарга, газарзүйн байрлал: Өмнөговь аймгийн нийт нутаг дэвсгэр нь Алтайн өвөр говь, Галба-Өөш-Долоодын говь, Онги, Таац, Умардын говийн гүвээт-Халхын голын гэсэн ай савуудад хамрагддаг байна. Аймгийн нутаг дэвсгэр ерөнхийдөө говь, цөлөрхөг хээр зонхилсон байх ба Говь Гурван Сайхан уулын Байгалийн нөөц газар, Загийн ус Байгалийн цогцолборт газар, Говийн бага (А, Б) Дархан цаазтай газар зэрэг улсын тусгай хамгаалалттай газрууд байна. Аймгийн нутаг төв хэсэгтээ хамгийн өндөрлөг буюу далайн түвшнээс дээш 2800м, бусад хэсэгтээ нам дор газар буюу д.т.д 1090м орчим өндөрт өргөгдсөн байна. Монгол орон өргөргийн дагуу сунаж тогтсон, хойноосоо урагш чиглэлд байгалийн эрс тэс онцлог бүхий уулын тайга, өндөр уул, ойт хээр, нугат хээр, хээр, хуурай хээр, цөлжүү хээр, заримдаг цөл, умардын цөл, жинхэнэ цөл, говь цөл гэсэн бүс бүслүүрүүд оршдог. Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр хуурай хээр, цөлийн хээр, умардын цөл, заримдаг цөл, цөл, жинхэнэ цөл гэсэн бүс бүслүүрт ямар нэгэн хэмжээгээр хамрагдаж байна

Өмнөговь аймгийн нутгийн баруун тал, төв хэсэг рүү Говийн Алтайн нурууны салбар уулс түрж ордгоос аймгийн баруун болон төв хэсэг нь нилээд уулархаг байдалтай юм. Аймгийн нутгийн зүүн хойт хэсэгт орших Шанхай Өгөөмөрийн жижиг уул, нуруудыг оруулаад, нийт уул нуруудын эзлэх талбай аймгийн бүх нутгийн 18%-ийг эзэлнэ. Энэ байдлаас үзэхэд аймгийн нутаг нь ерөнхийдөө талархаг байдалтай байна. Талархаг гадаргуутай нутаг нь дотроо: жижиг уулс, цав толгод, ухаа гүвээ талархаг газар, хотос хонхортоо хужир марзтай тойром, жижиг довцог элс, манхан бүхий нам дор газар гэсэн хоёр хэсэгт хуваагдах бөгөөд жижиг уулс, цав толгод ухаа гүвээ бүхий талархаг газар нь аймгийн нутгийн зүүн хойт хэсэгт, өндөр уулсын бэл дагуух нутгуудыг хамарч аймгийн нийт нутгийн 56%-ийг эзэлнэ. Харин хотос хонхортоо хужир марзтай тойром, жижиг довцог элс, манхан бүхий нам дор газарт аймгийн нутгийн хойт хэсгээр түрж орж ирэх Олон нууруудын хөндийн төгсгөл болох Онгийн голын адаг, Улаан нуурын сав дагуух нутаг болон Борзон Галбын говь, тэрчлэн Нэмэгт уулын ар хоолой, Ингэн сэвстэй, Цайлангийн говийг дайрч улсын хилийн дагуу үргэлжлэх Алтайн өмнөд говийн зүүн үзүүр болох нам дор газар нутгууд орно. Нам дор газрууд нь аймгийн нутгийн 26%-ийг хамарна. Аймгийн газар нутгийн гадаргуугийн энэхүү онцлог шинж нь аймгийн байгаль цаг уурын нөхцөлд зохих ёсны нөлөөг үзүүлдэг. Тухайлбал тус аймгийн баруун өмнөт талын нам дор нутгуудад намрын хүйтрэлт нилээд аажуу орж, хавар эрт дулаардаг бол уулархаг нутаг, түүний дотор Гурвансайханы нуруу дагуух нутгуудад намар эрт хүйтэрч, хавар хожуу дулаардгаас хүйтний улирал харьцангуй урт болдог байна. Тус аймгийн нутгийн уул нурууд нь баруунаасаа зүүн тийш чиглэсэн тогтоцтой, урт сунгуу хэлбэртэй юм. Мөн уул нурууд нь хоорондоо элсэн довцог, манхан хужир марзтай хотос, тойром элбэгтэй нарийн хөндий хоолойнуудаар зааглагдана. Түүнчлэн хойноосоо урагш үелэж зэрэгцсэн байрлалтай болно.

Тус аймгийн нутагт нийтдээ 32.2 мян.га талбайг элс эзэлж байна. Үүний 40 орчим хувийг нүүдэг элс эзэлдэг. Сэврэй сумын Хонгорын элсэн уул нь 180-д км урт, зарим газартаа 20 км өргөн юм. Аймгийн газрын гадаргуугийн өндөршилтийн зургаас үзэхэд далайн түвшнээс дээш 1000 метр хүртэл өргөгдсөн нутаг 5321.7 м.га, 1000-1400 метрт 8633.0 мян.га, 1400-1800 метрт 2074.9 мян.га, 1800-2400 метрт 468.2 мян.га, 2400 метрээс дээш өргөгдсөн нутаг 18.5 мян.га байна. Өөрөөр хэлбэл нийт нутгийн дийлэнх хувийг далайн түвшнээс дээш 1000-1400 метрт өргөгдсөн жижиг уул, толгод, ухаа гүвээ, тэгшивтэр гадаргуутай нутаг эзэлж байна

Уур амьсгал: Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр нь Төв Азийн хуурай, хуурайдуу говь, цөлийн бүсэд багтах бөгөөд далайн түвшинээс дээш 1300-1600м-н дундаж өндөрт оршино. Нутаг дэвсгэрийн хувьд хайрга чулуу элс ихтэй тачир сийрэг бэлчээрийн ургамалтай, уул нуруу, хонхор хөндий, тэгш тал, говь цөл алаглан оршдог. Эх газрын хуурай сэрүүн, эрс тэс

уур амьсгалтай, өргөрөгийн дагуу буюу баруун талын уулархаг нутгаасаа зүүн тийш говь уруугаа болох тусам дулаардаг хуурай агаартай хөрсөнөөс уурших чийгийн нөөц бага, агаар нэн хуурай учираас хур тунадасны хэмжээ бага, салхи ихтэй учир шороон шуургатай өдрийн тоо олон байдаг. Энэ онцлогоороо хөрсний физик өгөршүүлэл ихтэй, тариалан эрхлэхэд тохиромжгүй байдаг ч нар салхины эрчим хүчний их нөөцтэй нутаг юм.

Дорноговь аймаг: Монгол орны зүүн өмнөд хязгаарт Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар аймгуудтай хил залган оршдог. Аймгийн төв нь Сайншанд хот. Хойд, урд хоёр гүрнийг холбосон, төвийн бүсийн хөгжлийн гол тэнхлэг болсон төмөр зам дайран өнгөрдөг. Энэ замын дагуу тус аймгийн бүх сумын 42,8 хувь, хүн амын 54,8 хувь нь оршин суудаг. Хилийн байнгын үйл ажиллагаатай Замын-Үүдийн, улирлын ажиллагаатай Баянбулаг-Мандалын боомтуудтай. “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс байгуулах эрх зүйн орчин бүрдсэнээр Монгол улсын хөгжил дэвшлийн нэгэн үүд хаалга болж хөгжих ирээдүйтэй.

Боловсрол эрүүд мэнд: Манай аймагт ЭМШУҮИС-ийн Дорноговь аймаг дахь салбар сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Төмөр замын МСҮТөв, Ерөнхий боловсролын төрийн өмчийн 21, хувийн 1 сургууль, 17 дотуур байр, төрийн өмчийн 32, хувийн 4, төмөр замын 4 цэцэрлэг, эрүүл мэндийн 100 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Говийн догшин ноён хутагт Данзанравжаагийн нэрэмжит “Саранхөхөө” театр, Иргэдийн хөгжил төв, Усан спорт сургалтын төв, Төв номын сан, Музей сургалт судалгааны төв, Ноён хутагт Данзанравжаагийн музей, Орон нутгийн 2 телевиз, “Өнөөгийн Дорноговь” сонин зэрэг соёл мэдээллийн байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж байна.

Аж үйлдвэр тээвэр: Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2018 оны эцэст 230.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 68.5 (42.2%) тэрбумаар өссөн байна. Үүнд уул уурхайн салбарын үйлдвэрлэлт 55.1 хувиар, боловсруулах салбарын үйлдвэрлэл 27.8 хувиар, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамжийн салбарын үйлдвэрлэл 38.0 хувиар тус тус өсчээ.

Гадаргад нь кайнозойн эриний хурдас их тархсан бөгөөд хайлуур жоншны орд олонтой. Зэс молибден (цагаан суварга), чулуун нүүрс (Алагтоого), төмөр (Чандмань уул) болон барилгын материалын баялаг бий. Хайлуур, жонш олборлох уурхай байдаг. Дорноговь аймгийн нутгаар төмөр зам нэвтрэн өнгөрөх бөгөөд Сайншанд хот нь манай орны төмөр замын чухал зангилаа юм. Дорноговь аймгийн Замын-Үүд, Хангийн хилийн боомт нь Монголоос Хятад руу гарах хилийн том боомт юм.

2.2 Сумдуудын байгаль орчин, нийгэм эдийн засгийн ерөнхий мэдээлэл

Өмнөговь аймаг Цогтцэций сум: Цогтцэций сум нь 72.5 хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй, Алтайн уулархаг мужид багтдаг. Нийслэлээс 540 км, аймгийн төвөөс 100 км зайд, өөрийн аймгийн Цогт-Овоо, Манлай, Баян-Овоо, Ханхонгор, Ханбогд, Номгон сумдтай, Дундговь аймгийн Өлзийт сумтай хиллэн, далайн түвшинээс 1200-1791 м-ийн өндөрлөгт орших бөгөөд бүхэлдээ говь цөлийн бүсэд хамаарна.

Булаг, шанд, уул, толгод, говь хөндий, хоолой хослосон байгалийн эрдэнэс баялагаар баян, Монгол Улсын баатар эмэгтэй Т.Борын өлгий нутаг, Гэсэр гэлэнгийн домогт хурдан хул мориор домголсон Говь шанхын хурдан удмын адуу, арвин баялаг нөөцтэй “Тавантолгой” нүүрсний орд зэргээр алдартай, нутаг юм.

Тус сум нь чулуун нүүрс, Гөлтгөнө, галд тэсвэртэй шавар, алт, зэс, хужир зэрэг эрдэс баялгаа хөрсөн дороо агуулсанаас гадна эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй бөгөөд сүүлийн жилүүдэд уул уурхай эрчимтэй хөгжиж түүнийг даган сум орон нутагт дэд бүтэц хөгжиж, хөгжил цэцэглэлтийн шинэ эрин үетэй зэрэгцэн хөгжих боломж бүрдсэн нутаг юм. “Таван толгой” ХК, “Энержи ресурс”, “Эрдэнэс таван толгой” зэрэг уул уурхайн томоохон компаниуд олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулж орон нутгийн хөгжил

цэцэглэлтэнд хувь нэмрээ оруулж байна. Засаг захиргааны анхан шатны нэгж болсон 4 багтай, Сумын хэмжээнд 6 төсөвт байгууллага үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

Өмнөговь аймаг Манлай сум: Одоогоос 270 гаруй жилийн тэртээ байгуулагдсан Түшээт хан аймгийн Сүндэв гүний хошуунаас 9 ноён үе залгамжлан захирч ирсэн хошуу нутагт өнөөгийн Манлай сум 1924 онд анх байгуулагджээ. Улаанбаатар хотоос урагш 470 км, аймгийн төвөөсөө зүүн тийш 230 км зайд өөрийн аймгийн Ханбогд Цогтцэций, Баян-овоо болон Дундговь, Дорноговь аймгуудтай хил залган оршдог. Тус сум нь Засаг захиргааны анхан шатны нэгж болсон дөрвөн багтай. Сумын эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй.

Сүүлийн 5 жил дараалан адуугаараа аймагтаа тэргүүлж яваа хурдан адууны өлгий нутаг. Нутгийн хурдан удмаас Хүй мандал 1917 оны үед Улхийн булан гэдэг газар болсон 7 хошуу даншиг наадмуудад түрүүлж айрагдаж байсан тухай тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Мөн нутгийн иргэн Ц.Оюунбаатарын санаачилсан “Тэмээн поло” спортыг орон нутагтаа хөгжүүлэхэд онцгой анхааран ажиллаж тодорхой амжилтанд хүрч байгаа Эдийн засгийн хөгжлийн бас нэг гол суваг нь Оюутолгой, Гашуун сухайтын хилийн боомтыг Улаанбаатартай холбосон төв зам, Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр аймгийн төв дөрвөн замын уулзвар дайран өнгөрдөг их замын газар бөгөөд цаашид Дундговь аймгийн Өлзийт сумын Өөш манханы элсэн сувиллаас Морин толгойн цав, Өехий, Сэвхүүл, Могойт, Хоёр өлзийт уул, Ханбогд уул, Баян гол, Амтгай, Аргалант, Сүйхэнт, Өлгий хийд, Ханбогд сумын Галбын гурван хийд хүртэл аяллын маршрут зохион байгуулбал 100-150 км замд Манж Чин улсын үеийн өртөө замын үлдэгдэл, байгалийн сонин тогтоц бүхий газар орон чулуужсан яс, мод, загасны болон ургамлын дүрс бүхий чулуу, аргаль, янгир, хар сүүлт үзэхийн зэрэгцээ хулан, элсэн манхан, тэмээ, заган ой зэргийг нэг дороос үзэх, зураг авах боломжтой аяллын чиглэл гаргаж болох онцлогуудтай сум юм.

Өмнөговь аймаг Ханбогд сум: Хээр таль, говь цөл хосолсон 1515.2 кв.км нутаг дэвсгэртэй. Аймгийн төвөөс 260 км зайтай. Өмнөд хэсгээрээ БНХАУ-тай хиллэдэг. Өмнөговь аймгийн есөн гайхамшигийн нэг Галбын говь энэ сумын нутагт оршдог. Тус сум засаг захиргааны анхан шатны нэгж болсон 4 багтай. Сумын хэмжээнд 6 төсөвт байгууллага үйл ажиллагаа явуулж түүнд 100 гаруй төрийн албан хаагч ажилладаг. Газрын хөрсөндөө алт зэсийн арвин баялаг нөөцтэй, эрт галавын үеийн аварга гүрвэл, мөлхөгчдийн үлдэгдэл, чулуужсан мод зэрэг ховор олдворуудтай.

Ханбогд сумаас баруун тийш 40 км зайд дэлхийд томд тооцогдох зэс, алтны уурхай болох Оюу толгой үйл ажиллагаа явуулдаг. Монгол улсын эдийн засагт үлэмж хэмжээний үр ашиг авчрах аварга том уурхайн төсөл бөгөөд 2017 оны 12-р сарын 27-нд баяжуулах үйлдвэр нь ашиглалтанд орсон. Ханбогд сумаас баруун урагш 12 км зайд дуу шүлгэнд мөнхөрсөн Галбын говьд Ноён хутагт Данзанравжаагийн байгуулсан алдарт гурван хийдийн туурь, Цогзолын хийдийн туурь Алтангэрэлийн дугуй, Ловончомбын баяжуулдаг Чавгын агуй, Ходоод ба нүдний рашаан, элэг цэсний чулуу зэрэг байгаль түүхийн сонин тогтоц бүхий олон дурсгалт газруудтай. Дэмчогийн хийдийг Өмнөговийн “Ажнай” корпорациас санхүүжүүлэн сэргээн босгосон нь дотоодын аялал хөгжүүлэх боломжийг бүрдүүлсэн. Дэмчогийн хийдээс баруун хойно 6 км орчимд “Дэлхийн энергийн төв” жуулчны бааз байгуулагдсан. Сумын төвд цэвэр, бохир усанд холбогдсон цөөнгүй зочид буудал, ресторанууд үйл ажиллагаа явуулдаг.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 Байгаль орчны шууд ба шууд бус сөрөг нөлөөлөл

Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн хүнд даацын хатуу хучилттай автозам байгуулах төслийн үйл ажиллагаанаас үүдэн төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийн хураангуйг доорх хүснэгтэд тоймлон үзүүлэв.

Хүснэгт 1. Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн хүнд даацын хатуу хучилттай автозам байгуулах төслийн байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Шууд нөлөөлөл
Зам барилгын ажлын улмаас болон төслийн талбайн орчин тойронд олон салаа зам үүссэнээс тоосжилт үүсэх, хөрс эвдрэх
Ургамлан нөмрөг устах, ургамлын төрөл зүйл хомсдох, бэлчээрийн ургамал хомсдсоноос бэлчээрийн талбай багасах
Битум, шатах, тослох материалаар газар, хөрс, ус бохирдох
Зам байгуулах явцад шинээр карьер үүсгэснээс газар, хөрс эвдрэлд орох
Ажиллагсдын түр сууц, тосгон, түүний цогцолбороос байгаль орчин, хүний эрүүл мэндэд таагүй нөлөөлөл учруулах
Газар шорооны ажлын үед болон замын байгууламж байгуулах, нүх суваг шуудуу татсанаас газрын эвдрэл үүсэх
Хөрс гулсах, нурах, урсах зэргээр хөдөлгөөнд орж, замын ховилд орох, замыг эвдрэлд оруулах
Замын урсац зайлуулах хоолой, шуудуугаар урсах усны урсгалын нөлөөгөөр замын байгууламж болон ойр орчмын газар, хөрс эвдрэлд орох
Байгалийн өнгө, төрх байдал өөрчлөгдөх
Автомашин, тээврийн хэрэгслийн дуу чимээ нэмэгдсэнээс ан амьтан дайжих, байршил тархалт нь өөрчлөгдөх, амьдрах орон зай нь хумигдах
Шууд бус нөлөөлөл
Зам барьж байгуулснаар дэд бүтэц хөгжин хүн амын төвлөрөл ихэсч, хууль бус агнуур, хууль бусаар мод огтлох, бэлтгэх, тээвэрлэх үйл ажиллагаа эрчимжих
Зам, дэд бүтцийн хөгжлийг дагаж хууль бус ан агнуур хийх явдал ихсэх, ан амьтны нөөц хорогдох, амьдрах орчин нь өөрчлөгдөх
Биологийн төрөл зүйл өөрчлөгдөх, нөөц нь хомсдох
Бусад нөлөөлөл
Зам барьж байгуулах явцад олон салаа зам гарснаас орчны хөрс эвдрэх, агаарын тоосжилт ихсэх, ургамлын бүрхүүл хомсдох
Хүчтэй аадар бороо орж, карьер усанд автах, уруйн үерт автах
Ахуйн бохир ус, шатах тослох материал хөрсөнд нэвчих, хог хаягдал хадгалах цэгт ариутгал, халдваргүйжүүлэлт хийхгүй байх, ариун цэврийн дэглэмийг сахиагүйн улмаас эвгүй үнэр, халдварт өвчин гарах

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

4.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт

“ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС” ХХК-ийн “Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн хүнд даацын хатуу хучилттай автозам байгуулах” төслийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2020 онд “Мон газар экологи” ХХК-ний боловсруулсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зөвлөмж, зорилтууд Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29–ний өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэргийг мөрдлөг болгон төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг гол зорилго болгосон.

Байгаль хамгаалах ажлын хүрээнд авто замын төслийн талбайн болон тосгоны байгаль хамгаалалтын хүрээнд хамаарагдах ногоон байгууламж, хөрсний хамгаалалт багтах бөгөөд мониторингийн асуудалд агаарын чанарын хяналт, хөрсний бохирдол, орон нутгийн байгууллагын бодлогын хүрээнд шийдвэрлэн хамтран ажиллах үйл ажиллагаа багтана. Харин хүрээлэн буй орчны байгаль хамгаалалын асуудалд тус нутгийн экологийн иж бүрэн системийн хүрээнд шийдвэрлэгдлэх асуудлууд багтана.

Мөн 2022 онд Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто замын төслийн үйл ажиллагааг орон нутгийн байгаль хамгаалах ажилтай уялдуулан явуулахдаа байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг судлан түүний нөлөөллийн мониторингийг хоёр түвшинд авч хянан нөлөөллийг авч үзсэн.

Үүнд:

- Авто замын трассын дагуух орчны байгаль хамгаалах үйл ажиллагаа, мониторинг
- Хүрээлэн буй орчны буюу нөлөөллийн радиуст (экологийн системийн үйлчилэх хүрээний радиусыг биологийн төрөл зүйлээс хамааран 50-100 км зайд авч үздэг практик бий) хамаарагдах нөлөөлөлийн мониторинг зэрэг болно.

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөрс болон ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах, усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, амьтны аймагт үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах арилгах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн авч үзсэн.

5.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Хүрээлэн буй орчны агаарын чанарт нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Төлөвлөгөөний хэрэгжилтэнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ мян.төг	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
Агаар, орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт				
1	Төслийн талбай орчимд авто зам барих явцад ашиглаж буй машин тоног төхөөрөмжийн хурдыг хязгаарлах	Төсөл хэрэгжиж буй талбай	Үйл ажиллагааны зардалаар зохицуулагдах учир зардал төлөвлөгдөөгүй	Авто замын төслийн талбайд үйл ажиллагаа явуулж буй бүх туслан компаниуд болон тэдгээрийн байгаль орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэнүүд авто замын төсөл дээр ажиллаж байгаа бүх төрлийн авто машины жолооч нарт ХАБЭАБО-той холбоотой зааварчилгааг тогтмол өгч, холбогдох газруудад тэмдэг тэмдэглэгээг байршуулж, төслийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.
2	Түр замын арчилгаа засварт хяналт тавьж сайжруулсан замаар замын түүхий эдийг зөөх	Карьераас тавьж буй зам хүртэл	Дотоод төлөвлөлтөөр	Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 478.86 км авто замын арчилгааг тогтмол хийж байна.

3	<p>Түр замаар тээвэр хийж буй аж ахуй нэгжүүдэд замаас гадуур шинэ зам үүсгэн явах, тээврийн жолооч нарын байгаль хамгаалах үүрэг хариуцлагыг сайжруулах, ил задгай хог хаягдал хаях, зориулалтын бус газарт засвар үйлчилгээ хийх, маршрутын бус замаар тээвэр хийх зэрэг зөрчил дутагдалд тухай бүр шаардлага тавьж дутагдал илрэхгүй байх нөхцлийг хангах, тухайн компанийн удирдлагуудад үүрэг болгох</p>	<p>Цогтцэцийгээс – Ханги хүртэлх тээврийн зам дагуу</p>	<p>Үйл ажиллагааны зардалаар</p>	<p>Туслан гүйцэтгэгч компаниудын хариуцсан мэргэжилтэнүүд тээвэрт явж байгаа жолооч нарт хуваарийн дагуу сургалт орох, маршрутын бус замаар тээвэр хийхийг хориглох, хурдны хязгаарын баримтлах, жолооч нарт хогийн уутыг тогтмол өгч хогийн цэг дээр хог хогоо хаях зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажиллаж байна.</p>
4	<p>Тоосжилтыг бууруулахын тулд усалгаа хийж агаар орчныг чийгшүүлэх, усалгааг үр дүнтэй зохион байгуулах</p>	<p>Цогтцэцийгээс – Ханги хүртэлх тээврийн зам дагуу</p>	<p>Дотоод төлөвлөлтөөр</p>	<p>Авто замын төсөл дээр үйл ажиллагаа явуулж буй бүх туслан компаниуд өөрсдийн хариуцсан хэсэг тус бүрт тоосжилт ихтэй үе болон хаврын улирал буюу ургамал ургах үед зам дагуух усалгааны ажлыг тогтмол зохион байгуулж ажиллаж байна. Мөн түүнчлэн зам арчилгаа болон хурдны хязгаарлалтын дүрэм журмыг мөрдүүлэхэд анхаарч ажиллаж байна.</p> <p>Энэ жил Өмнөговь аймгийн Цогтцэций, Манлай, Ханбогд, Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутгаар өмнө жилтэй харьцуулахад харьцангуй хуурайшилттай, бороо хур багатай жил байсан тул усалгааны ажлыг тогтмол зохион байгуулж ажилласан.</p>



5	Машин тоног төхөөрөмжийг зам талбайд ашиглаагүй нөхцөлд тогтмол унтраах	Төслийн хэмжээнд	Дотоод төлөвлөлтөөр	Төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй машин, техникүүдийг ашиглахгүй үед унтраагаагүйгээс үүдэн байгаль орчинд болон агаарт олон төрлийн хорт хийнүүд ялгарах учир машин, техникүүдийг ашиглаагүй үед тогтмол унтрааж байхыг байгаль орчны мэргэжилтнүүд, ХАБЭА-н ажилтануудад тогтмол хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосон.
6	Техникийн үзлэг оношлогоог мото цагийн дагуу тухай бүрт хийж бохирдуулагч хий үүсгэх нөхцөл бүрдэхээс урьдчилан сэргийлэх	Төслийн хэмжээнд	Дотоод төлөвлөлтөөр	Төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй техникийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих, үзлэг оношлогоонд оруулах зэрэг ажлыг холбогдох механик инженер, ХАБЭА-н ажилтанууд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

5.1.1 Авто зам барих явцад ашиглаж буй тоног төхөөрөмжийн хурдыг хязгаарлах

Авто замын бүтээн байгуулалт, үйл ажиллагаа явуулж буй ЛОТ-1, ЛОТ-2, ЛОТ-3, ЛОТ-4, ЛОТ-5, ЛОТ-6 бүх туслан гүйцэтгэх компаниуд жолооч нар түр замаар тээвэр хийхдээ хурд хэтрүүлэн тоосжилт үүсгэх, маршрут тэмдэг тэмдэглэгээний заалтыг зөрчиж дур мэдэн өөр зам гаргаж их хэмжээний тоосжилт үүсгэхээс урьдчилан сэргийлж авто замын төслийн талбайд үйл ажиллагаа явуулж буй бүх туслан компаниуд болон тэдгээрийн байгаль орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэнүүд авто замын төсөл дээр ажиллаж байгаа бүх төрлийн авто машины жолооч нарт ХАБЭАБО-той холбоотой зааварчилгааг тогтмол өгч, холбогдох газруудад тэмдэг тэмдэглэгээг байршуулж, төслийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажилласан.




Зураг 2. ЛОТ-1 Ундарга-Од ХХК-ний технологийн зам буюу түр замын тэмдэг тэмдэглэгээ хийсэн байдал



Зураг 3. ЛОТ-2 Синохайдро Корпорэйшн ХХК-ний технологийн зам буюу түр замын тэмдэг тэмдэглэгээ хийсэн байдал





Зураг 4. ЛОТ-3,4-7 Чайна Гео Инженеринг Корпорэйшн ХХК-ний технологийн зам буюу түр замын тэмдэг тэмдэглэгээ хийсэн схем



Зураг 5. ЛОТ-6 НДТК ХХК-ний технологийн зам буюу түр замын тэмдэг тэмдэглэгээ хийсэн байдал

5.1.2 Түр замын арчилгаа засвар, сайжруулалт хийж хяналт тавих

Өмнөговь аймгийн Цогтцэций, Манлай, Ханбогд суманд хийсэн зам арчилгаа засварын ажил.

Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 478.86км авто замын 250км орчим нь Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрч байна. Уг авто замын барилгын ажлыг гүйцэтгэхийн хажуугаар нүүрс тээврийн түр замын засвар арчлалтыг байнгын хийж гүйцэтгэж байна.


Нүүрс тээврийн түр зам нь 9м өргөнтэй, 0.3м-0.5м зузаан хайрган хучилт бүхий авто зам хийгдэж байгаа ба 2022.09.10-ны байдлаар Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт нийт **200км** түр замд шинээр хайрган далан барих, арчилах ажлыг хийж гүйцэтгээд байна.

Хүснэгт 2. Өмнөговь аймагт хийсэн зам арчилгааны мэдээлэл

№	Байрлал	Далангийн ажил			
		Урт, м	Өргөн, м	Зузаан, м	Нийт тоо хэмжээ, м3
1	Төмөр замын түр замын засвар 123,4км	100000.00	9	0.3	270,000
2	LOT2. Section 4	19900.00	9	0.3	53,730
3	LOT3. Section 5	30000.00	9	0.3	81,000
4	LOT3. Section 6	43700.00	9	0.3	117,990
		200km			522,720

Хүснэгт 3. Ажиллаж буй машин механизм, хүн хүчний мэдээлэл

Машин механизм			Хүн хүч		
№	Машин механизмын нэр	Тоо ширхэг	№	Албан тушаал	Хүний тоо
1	Автогрейдэр	6	1	Удирдах ажилчин	4
2	Өөрөө буулгагч	120	2	Инженер	6
3	Далангийн индүү	10	3	Жолооч	140
4	Усны машин	8	4	Оператор	24
5	Экскаватор	6	5	Туслах ажилчин	25
6	Авто ачигч (ковш)	8	Нийт		199
7	Түлшний машин	4			
8	Трайлер	4			
9	Хөнгөн тэрэг	8			



Зураг 6. Түр замын арчилгаа сайжруулалт хийж буй байдал /Өмнөговь аймаг/

Дорноговь аймгийн Хатанбулаг суманд хийсэн зам арчилгаа засварын ажил

Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 478.86км авто замын 230км нь орчим нь Дорноговь аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрч байна. Уг авто замын барилгын ажлыг гүйцэтгэхийн хажуугаар нүүрс тээврийн түр замын засвар арчлалтыг байнгын хийж гүйцэтгэж байна.

Нүүрс тээврийн түр зам нь 10м өргөнтэй, 0.3м-0.5м зузаан хайрган хучилт бүхий авто зам хийгдэж байгаа ба 2022.09.10-ны байдлаар Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт нийт **110км** түр замыг шинээр хийж гүйцэтгээд байна.

Хүснэгт 4. Дорноговь аймагт хийсэн зам арчилгааны мэдээлэл

№	Байрлал	Далангийн ажил			
		Урт, м	Өргөн, м	Зузаан, м	Нийт тоо хэмжээ, м3
1	LOT3. Section 6	6200.00	10	0.3	18600
2	LOT4. Section 7	42000.00	10	0.3	126000
3	LOT4. Section 8	51900.00	10	0.3	155700
4	LOT4. Section 9	10000.00	10	0.3	30000
		110.1км			330300

Хүснэгт 5. Ажиллаж буй машин механизм, хүн хүчний мэдээлэл

Машин механизм			Хүн хүч		
№	Машин механизмын нэр	Тоо ширхэг	№	Албан тушаал	Хүний тоо
1	Автогрейдэр	4	1	Удирдах ажилчин	3
2	Өөрөө буулгагч	60	2	Инженер	5
3	Далангийн индүү	6	3	Жолооч	74
4	Усны машин	4	4	Оператор	22
5	Экскаватор	6	5	Туслах ажилчин	20
6	Авто ачигч (ковш)	6		Нийт	124
7	Түлшний машин	2			
8	Трайлер	2			
9	Хөнгөн тэрэг	6			
	Нийт	96			






Зураг 7. Түр замын арчилгаа сайжруулалт хийж буй байдал /Дорноговь аймаг/

5.1.3 Түр замаар тээвэр хийж буй тухайн компанийн удирдлагуудад үүрэг өгөх.

Цогтцэцийгээс Ханги хүртэлх түр замаар тээвэр хийж буй аж ахуй нэгжүүдэд түр замаас гадуур шинэ зам үүсгэн явах, тээврийн жолооч нарын байгаль хамгаалах үүрэг хариуцлагыг сайжруулах, ил задгай хог хаягдал хаях, зориулалтын бус газарт засвар үйлчилгээ хийх, маршрутын бус замаар тээвэр хийх зэрэг зөрчил дутагдалд тухай бүр шаардлага тавьж дутагдал илрэхгүй байх нөхцлийг хангах, тухайн компанийн удирдлагуудад үүрэг болгож, туслан гүйцэтгэгч компаниудын байгаль орчин, ХАБЭА хариуцсан мэргэжилтэнүүд тээвэрт явж байгаа жолооч нарт хуваарийн дагуу сургалт орох, маршрутын бус замаар тээвэр хийхийг хориглох, хурдны хязгаарын баримтлах, жолооч нарт хогийн уутыг тогтмол өгч хогийн цэг дээр хогоо хаях зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажилласан.



Зураг 8. Замын хөдөлгөөний удирдлагын журам



Зураг 9. Жолооч нарт байгаль орчны сургалт заавар зөвлөмж



Зураг 10. Удирдлага болон жолооч нарт байгаль орчны сургалт заавар зөвлөмж

5.1.4 Тоосжилтыг бууруулахын тулд усалгаа хийж агаар орчныг чийгшүүлэх

Авто замын төсөл дээр үйл ажиллагаа явуулж буй бүх туслан компаниуд өөрсдийн хариуцсан хэсэг тус бүрт тоосжилт ихтэй үе болон хаврын улирал буюу ургамал ургах үед зам дагуух усалгааны ажлыг тогтмол зохион байгуулж ажиллаж байна. Мөн түүнчлэн зам арчилгаа болон хурдны хязгаарлалтын дүрэм журмыг мөрдүүлэхэд анхаарч ажиллаж байна. 2022 онд Өмнөговь аймгийн Цогтцэций, Манлай, Ханбогд, Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутгаар өмнө жилтэй харьцуулахад харьцангуй хуурайшилттай, бороо хур багатай жил байсан тул усалгааны ажлыг тогтмол зохион байгуулж ажилласан.



Зураг 11. Түр замын усалгааг тогтмол хийж буй байдал

5.1.5 Машин тоног төхөөрөмжинд тогтмол хяналт тавих

Автозамын төсөл дээр ажиллаж буй машин, техникүүдийг унтраагаагүйгээс үүдэн нүүрстөрөгчийн дутуу болон давхар исэл, хүхэрлэг хий, хөө тортог, хар тугалга, кадми, альдегид зэрэг 270 гаруй

төрлийн хорт бодис агаарт ялгаруулдаг. Төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй машин, техникүүдийг ашиглаагүй тохиолдолд унтраах, техникийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих зэргийг туслан гүйцэтгэгч компаниудын байгаль орчны мэргэжилтнүүд, ХАБЭА-н ажилтнууд, механик инженерүүдэд үүрэг өгч, хяналт тавьж ажилласан.

5.2 Хөрс ургамалан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Зардалын хэмжээ мян.төг	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
Хөрс, ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний хэрэгжилт				
1	Олон салаа зам үүсгэхгүй байх, ажилчдын дотоод журам, ХАБ-н зааварчилгаа сануулах мэдээллэх	Төсөл хэрэгжиж буй талбайд	Дотоод төлөвлөлтөөр	Төслийн замын хөдөлгөөний удирдлагын журмын 6.1 тусгаж ажилчдад танилцуулах ажлыг зохион байгуулсан. Хэд хэдэн газар салаа зам үүсгэсэн газруудыг хаах ажлыг зохион байгуулж ажилласан.
2	Шимт хөрс /өнгөн хөрс хуулалт/ хуулах нөхөн сэргээлтэд туслан гүйцэтгэгч компаниудад хяналт тавих	Төслийн хэмжээнд эвдрэлд орж буй талбай	Дотоод төлөвлөлтөөр	Төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй түгээмэл тархацтай ашиглаж буй шимт хөрсийг стандартын дагуу хуулж, хадгалах мөн тэдгээрийг тэмдэгжүүлэх шаардлагыг туслан гүйцэтгэгч компаниудад тогтмол тавьж ажилласан.
3	Техникийн засвар үйлчилгээг хөрсөнд бохирдол үүсгэхгүйгээр хийх	Нийт техникийн тоо хэмжээ	Дотоод төлөвлөлтөөр	Техникийн засвар үйлчилгээг хийхдээ зориулалтын хатуу хучилттай талбайд хийх, хөрс ШТМ-аар бохирдсон тохиолдолд саармагжуулах талбайд хусаж асгах шаардагуудыг тогтмол өгч ажиллаж байна. 2023 онд авто замын ажил эхлэх үед бүх зам туслан гүйцэтгэгч компаниудад засварын талбайг хатуу хучилттай болгохоор төлөвлөн ажилласан.
4	Биологийн олон янз байдлыг хамгаалах ажлын хүрээнд нэн ховор, ховор ургамал хууль бусаар түүж бэлтгэхтэй холбоотой постер хийх	Өмнөговь аймгийн өгсөн зөвлөмжийн дагуу	Үйл ажиллагааны зардалд багтсан	Биологийн олон янз байдлыг хамгаалах нэн ховор, ховор ургамлыг хууль бусаар түүж бэлтгэх, худалдаалах, үржүүлэхээс сэргийлсэн постер хийж гүйцэтгэсэн.

5.2.1 Олон салаа зам үүсгэхгүй байх, ажилчдын дотоод журам, ХАБ-н зааварчилгааг сануулах мэдээлэх

Төслийн замын хөдөлгөөний удирдлагын журмын 6.1 тусгаж ажилчдад танилцуулах ажлыг зохион байгуулсан. Хэд хэдэн газар салаа зам үүсгэсэн газруудыг хаах ажлыг зохион байгуулж ажилласан.



Энэхүү журманд заасан шаардлага болон бусад холбогдох журмуудын албан ёсоор танилцуулсан байна.

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

6.1. Авто замын төсөл дээр ажиллаж буй нийт жолооч нар маршрутын бус замаар тээвэр хийх, ил задгай хог хаягдал хаях, зорнулалтын бус газруудад засвар үйлчилгээ хийх, шинэ зам гаргахыг хориглоно.

ДОЛОО ЖУРАМ ЗӨРЧИГСДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Журам нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчлэх ба журмыг “Тн Тн Сн Тн” ХХК-ийн төслийн талбайнуудад тээврийн хэрэгсэлээр хөдөлгөөнд оролцож буй бүх компани (үндсэн, харьяат, гэрээт, гэрээтийн гэрээт) аж ахуй нэгжүүд дагаж мөрдөнө.

Зураг 10. Замын хөдөлгөөний удирдлагын журмын 6.1 дахь заалт

5.2.2 Шимт хөрс хуулах нөхөн сэргээлтэд туслан гүйцэтгэгч компаниудад хяналт тавих

Шимт хөрсийг хадгалж хамгаалах нь стратегийн өндөр ач холбогдолтой бөгөөд газар хөндөхөөс өмнөх үеийн ургамлан бүрхэвч болон биологийн төрөл зүйлийн амьдрах орчныг дахин бий болгох буюу нөхөн сэргээлтийг амжилттай хийхэд чухал үүрэгтэй юм. Ялангуяа говийн уур амьсгалын хатуу ширүүн нөхцөлд ургамлын үр үрсэлж, үндэсний систем хөгжихөд тохирсон хөрсний нөөц нэн шаардлагатай байдаг. Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулахаас өмнө хөрсний үе давхаргын зузааныг тодорхойлж, харилцан адилгүй тогтоосон гүн хүртэл шимт болон шимэрхэг хөрсийг хуулж овоолго үүсгэн, хадгалж, чанарын хяналт хийдэг. Зарим талбайд газрын гадаргын өнгөн хэсгээс хөрс үүсгэгч эх чулуулаг, хад, сайр чулуу эхэлдэг ба нөхөн сэргээлт хийхэд тохиромжгүй хэт шүлтлэг дунд шавранцар улаан шаврыг хуулж хадгалдаггүй.

Мөн төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглаж буй шимт хөрсийг стандартын дагуу хуулж, хадгалах мөн тэдгээрийг тэмдэгжүүлэх шаардлагыг туслан гүйцэтгэгч компаниудад тогтмол тавьж ажиллаж байна. Одоогийн байдлаар шимт хөрсний овоолгыг карьер тус бүрд нь овоолго үүсгэн хадгалж байна.



Зураг 12. Шимт хөрсний овоолго хадгалалт

5.2.3 Техникийн засвар үйлчилгээг хөрсөнд бохирдол үүсгэхгүйгээр хийх

Техникийн засвар үйлчилгээг хийхдээ зориулалтын хатуу хучилттай талбайд хийх, хөрс ШТМ-аар бохирдсон тохиолдолд саармагжуулах талбайд хусаж асгах шаардагуудыг тотмол өгч ажиллаж байна. 2023 онд авто замын ажил эхлэх үед бүх зам туслан гүйцэтгэгч компаниудад засварын талбайг хатуу хучилттай болгохоор төлөвлөн ажиллаж байна.



Зураг 13. Засвар үйлчилгээний талбай

5.2.4 Нэн ховор, ховор ургамал хууль бусаар түүж бэлтгэхтэй холбоотой постер хийх

Биологийн олон янз байдлыг хамгаалах нэн ховор, ховор ургамлыг хууль бусаар түүж бэлтгэх, худалдаалах, үржүүлэхээс сэргийлсэн постер хийж гүйцэтгэсэн.



Зураг 14. Төслийн зам дагуу хөндөгдөж болзошгүй ховор, нэн ховор ургамлуудын зурагт постер



Зураг 15. Байгалийн ховор, нэн ховор ургамлыг зөвшөөрөлгүйгээр түүж бэлтгэхийг хориглосон зурагт постер

5.3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Зардалын хэмжээ мян.төг	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний хэрэгжилт				
1	Төслийг хэрэгжүүлэх явцад ашиглах ус ашиглах тухайн жилийн дүгнэлтийг холбогдох газраар гаргуулах	Төслийн хэмжээнд	Дотоод төлөвлөлтөөр	2022 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Монгол Улсын Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраар унд ахуйн болон технологийн хэрэглээний усыг 18 худгаас зөөврөөр хангахаар усны дүгнэлтийг гаргуулсан.
2	Усны эх үүсвэр дээр суурилуулсан тоолуурын эвдрэл гэмтэлд хяналт тавьж ажиллах	Төслийн хэмжээнд ашиглах буй усны эх үүсвэр	Тоолуурын заалтаар	Төслийн хэмжээнд одоогоор ашиглаж буй 18 худгийг бүгдийг тоолууржуулсан бөгөөд тоолуурын баталгаажуулалтыг сар бүр тухайн орон нутгийн байгаль орчны байцаагчаар хийлгэн ажиллаж байна. Худаг тус бүрийн сар бүрийн тоолуурын баталгаажуулалт хийсэн акт, тоолуур суурилуулсан актуудыг “тайлангийн хавсралт” хэсэгт оруулсан.
3	Орон нутагтай усны гэрээ байгуулж төлбөр төлж ажиллах	Төслийн хэмжээнд ашиглах буй усны эх үүсвэр	Тоолуурын заалтаар	Усны газрын 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдөр гаргуулсан усны дүгнэлтийг үндэслэн 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр Галба-Өөш-Долоодын сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ хийсэн. Усны гэрээг тайланд хавсралтаар оруулав.
4	БОНХАЖСайд, Барилга хот байгуулалтын сайдын хамтарсан 2015 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/230/127 тоот тушаалаар баталсан Усны сан бүхий	Төслийн хэмжээнд ашиглах буй усны эх үүсвэр	Тоолуурын заалтаар	Төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй бүх худгуудад эрүүл ахуйн бүс тогтоолгох тухай хүсэлтийг харъяалагдах орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудад илгээсэн.



	газар, усны эх үүсвэрийн хамгаалалтын эрүүл ахуйн дэглэмийг мөрдөх журмын дагуу худаг уст цэгүүдэд хамгаалалтын бүс тогтоох			
5	Үерийн урсац өнгөрөөх шугам хоолойг зураг төслийн дагуу хийж гүйцэтгэх	Замын дагуу	Үйл ажиллагааны зардалд багтсан	Инженерийн геологийн нарийвчилсан судалгаанд үндэслэн боловсруулсан зураг төслийн дагуу шаардлагатай цэгүүдэд үерийн урсац өнгөрөөх шугам хоолойг суурилуулан ажиллаж байна.
6	Ус өнгөрүүлэх шугам хоолойг малчдын гар худаг, булаг шандаас хол хийх			Эдгээр шугам хоолойг барьж байгуулахдаа булаг шанд, малчдын гар худаг үерийн усанд лайтаж дарагдахаас сэргийлэн уст цэгүүдийн байршил судалгаанд үндэслэн зураг төсөл боловсруулагдсан болно.
7	Орон нутагтай хаягдал усны дүгнэлт, гэрээ, зөвшөөрлыг авах			

5.3.1 Төслийг хэрэгжүүлэх явцад ашиглах ус ашиглах тухайн жилийн дүгнэлтийг холбогдох газраар гаргуулах

Усны тухай хуулийн 28.4 заасны дагуу Монгол Улсын Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраар 2022 оны 3-р сарын 01-ны өдрийн 05/187 тоот албан бичгээр “Таван толгой-Манлай-Ханги чиглэлийн хатуу хучилттай авто зам барих” төслийн ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулсан.

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм”-ын дагуу тооцуулахад:

- 4,913,358.7м³ x 8% = 393,068.7м³ - Авто замын далан байгуулах ажлын усалгаанд ашиглах усны хэмжээ
- 15,728.5м³ x 0.3м³ = 4,718.6м³ - Бетон зуурмагт ашиглах усны хэмжээ
- 393,068.7м³ + 4,718.6м³ = 397,787.3м³ - Технологийн нийт ашиглах усны хэмжээ
- 800 хүн x 150л/хон x 180хон = 21,600.0м³ - Унд ахуйн усны хэрэгцээнд тус тус ашиглахаар тооцуулсан.

Үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 дэх заалтын дагуу ажилчдын унд ахуйн зориулалтаар ашиглах **21,600.0м³** усыг төлбөрөөс чөлөөлсөн.



Зураг 16. Усны газраас гаргасан 2022 оны ус ашиглах дүгнэлт

5.3.2 Усны эх үүсвэр дээр суурилуулсан тоолуурын эвдрэл гэмтэлд хяналт тавьж ажиллах

Төслийн хэмжээнд одоогоор ашиглаж буй 18 худгийг бүгдийг тоолууржуулсан бөгөөд тоолуурын баталгаажуулалтыг сар бүр тухайн орон нутгийн байгаль орчны байцаагчаар хийлгэн ажиллаж байна. Худаг тус бүрийн сар бүрийн тоолуурын баталгаажуулалт хийсэн акт, тоолуур суурилуулсан актуудыг **“тайлангийн хавсралт”** хэсэгт оруулсан.

Хүснэгт 6. Худгын тоолуурын мэдээлэл

№	Тоолуурын марк	Гэрчилгээний дугаар	Тоолуурын дугаар	Лацны дугаар	Тоолуурын голч
ЛОТ-1 Ундарга од ХХК					
1	LXSG-25	218383	202000425	22	50
2	LXSG		202002716	15	32
ЛОТ-2 Синохайдро корпорейшн монголиа ХХК					
1	LXSGR-40	2984	-	18	40
2	LXSGR-40	228217	-	15	40
3	LXSGR-40	2985	-	18	40
4	LXSGDN	230336	-	24	50
5	LXSGDN	219273	-	22	32
ЛОТ-3 Чайна гео инженеринг корпорейшн ХХК					
1	LXSG-32		202100297	14	32
2	LXSG-32		202100288	14	32
3	LXSG-33	-	2107000104	17	33
4	LXSG	-	2101100079	24	32
ЛОТ-4-8 Синохайдро корпорейшн монголиа ХХК					
1	LXSGDN-40	235077	-	24	40
2	LXSGDN-40	257657	-	21	40
ЛОТ-4-7 БИГ БОЛД ХХК					
1	CBM	12560		22	32
2	CBM	20587	-	22	32
ЛОТ-6 ЭН ДИ ТИ КЕЙ ХХК					
1	LXSGR-25E		15253	24	32
2	LXSGR-25E	202197	-	14	32
3	CBM 32X	193837	-	15	32



Зураг 17. Төслийн трассын дагуух худгуудын байршил

5.3.3 Орон нутагтай усны гэрээ байгуулж төлбөр төлж ажиллах

Монгол Улсын Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.14 дэх заалт, 28 дугаар зүйлийн 28.6 дахь заалтыг үндэслэн ГАЛБА-ӨӨШ-ДОЛООДЫН говийн сав газрын захиргааны даргын 2022 оны 03-р сарын 14-ны өдөр А/07 дугаартай тушаалаар ус ашиглах зөвшөөрлийг авсан. Зөвшөөрлийг үндэслэн ус ашиглах гэрээг 2022 оны 04-р сарын 11-ний өдөр байгуулсан.



ДОРНОГОВЬ АЙМАГ
ГАЛБА-ӨӨШ-ДОЛООДЫН ГОВИЙН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/07

Сайтанд сүм

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.14 дэх заалт, 28 дугаар зүйлийн 28.6, 28.8 дахь заалт, 29 дүгээр зүйл, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.20 дахь заалт, Засгийн газрын 2011 оны “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох тухай” 199 дүгээр тогтоолын 11.1.19 дэх заалт, Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 51 дүгээр тогтоол, Усны газрын 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 22 дугаар ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Өмнөговь аймгийн Цогтцэций, Манлай, Дорноговь аймгийн Хатанбулаг сумдын нутагт баригдах “Таван толгой-Манлай-Ханги чиглэлийн хатуу хучилттай авто зам барих” төслийг хэрэгжүүлэх “Тахилт хайрхан транс” ХХК-нд 2022 онд 419,387.3м³ усыг ахуйн болон авто замын барилгын ажилд дүгнэлтэд заасан эх үүсвэрээс ашиглахыг зөвшөөрсүгэй.

2.Ус ашиглах зөвшөөрлийн улсын тэмдэгтийн хураамж 200,000 (Хоёр зуун мянга), ус ашиглах гэрээний төлбөр 60,000 (Жаран мянган) төгрөгийг тус тус орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавих шаардлагыг ханган ажиллаж, усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ, тайланг 2022 оны 12 дугаар сарын 30-ны дотор ирүүлэхийг “Тахилт хайрхан транс” ХХК-ийн төсөл хариуцсан захирал (Хсу Хө Жүн)-д даалгасугай.

3.Усны ашиглах боломжит нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж, ус ашиглагчтай гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг дараа оны 1-р сард багтаан дүгнэж ажиллахыг Усны барилга байгууламж, үйлдвэр, хөдөө аж ахуйн ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн (Э.Жанчивдорж)-д үүрэг болгосугай.

ДАРГА




Б.ЯЛАЛТБАЯР

441700051

Зураг 18. 2022 оны ус ашиглах зөвшөөрөл

5.3.4 Худаг уст цэгүүдэд хамгаалалтын бүс тогтоох

БОНХАЖСайд, Барилга хот байгуулалтын сайдын хамтарсан 2015 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/230/127 тоот тушаалаар баталсан Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн хамгаалалтын эрүүл ахуйн дэглэмийг мөрдөх журмын дагуу төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй бүх худгуудад эрүүл ахуйн бүс тогтоолгох тухай хүсэлтийг харъяалагдах орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудад илгээсэн. Хүсэлт илгээсэн сумдуудаас Манлай сумын засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн А/97 тоот бичгээр эрүүл ахуйн бүс тогтоох захирамж гарсан.



Зураг19 . Манлай сумын засаг даргын эрүүл ахуйн бүс тогтоох захирамж



Зураг 20. Гүний худгуудыг хашиж тохижуулсан байдал

5.3.5 Үерийн урсац өнгөрөөх шугам хоолойг зураг төслийн дагуу хийж гүйцэтгэх

Инженерийн геологийн нарийвчилсан судалгаанд үндэслэн боловсруулсан зураг төслийн дагуу шаардлагатай цэгүүдэд үерийн урсац өнгөрөөх шугам хоолойг суурилуулан ажиллаж байна.





Зураг 21. Үерийн урсац өнгөрөөх шугам хоолой


5.3.6 Ус өнгөрүүлэх шугам хоолойг малчдын гар худаг, булаг шандаас хол хийх

Шугам хоолойг барьж байгуулахдаа булаг шанд, малчдын гар худаг үерийн усанд лайтаж дарагдахаас сэргийлэн уст цэгүүдийн байршил судалгаанд үндэслэн зураг төсөл боловсруулагдсан болно.

ХУУРИЙН ХУВИЙН
ТАВАН ТОЛГОЙ-МАНЛАЙ-ХАНГИ

№	Автомобильн замын диаметр D, м	Автомобильн замын диаметр D, м	Хөндөгний тусгал	Хөндөгний өнцөг α	Хөндөгний урт L, м	Төвлөлийн тэгшитгэл		Хөндөгний тусгал γ	Төвлөлийн тусгал γ	Хөндөгний тусгал γ	Хөндөгний тусгал γ	Хөндөгний тусгал γ	Хөндөгний тусгал γ
						Хөндөгний тэгшитгэл	Хөндөгний тэгшитгэл						
1	3	44-088	10	90	95.00	9.02	9.48	-1.0	104.88	104.88	1047.07	1047.87	
2	3	44-076	10	90	95.00	9.07	9.43	-1.0	104.70	104.81	1046.22	1046.22	
3	4	44-088	10	90	95.00	9.02	9.48	-1.0	105.27	104.99	1048.02	1048.72	
4	3	44-088	10	90	95.40	9.05	9.35	-1.0	105.14	104.28	1049.16	1049.01	
5	7	44-020	10	90	95.00	9.04	9.36	-1.0	104.05	104.30	1045.29	1045.16	
6	3	47-046	10	90	95.70	9.21	9.40	-1.0	103.82	104.14	1043.00	1043.00	
7	10	44-088	10	90	95.00	9.05	9.40	-1.0	104.38	104.23	1046.94	1046.85	
8	18	44-020	10	90	95.20	9.18	9.39	-1.0	104.73	104.38	1046.29	1046.20	
9	12	50-400	10	90	95.70	9.08	9.14	1.0	102.25	103.99	1043.00	1043.00	
10	10	50-400	10	90	95.20	9.24	9.30	1.0	104.16	104.00	1041.78	1041.97	
11	14	50-400	10	90	95.70	9.07	9.22	1.0	104.77	104.47	1046.38	1046.28	
12	10	50-400	10	90	95.00	9.09	9.28	1.0	104.45	104.07	1044.00	1044.82	
13	16	50-400	10	90	95.00	9.14	9.28	-1.0	104.04	104.21	1045.21	1045.11	

Зураг 22. Үерийн урсац өнгөрөөх шугам хоолойн мэдээлэл



Зураг 23. Батлагдсан зураг төсөл

5.4 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Зардалын хэмжээ мян.төг	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	Гал тогооноос гарах хог хаягдлыг тухай бүр булшлах, нийт ажиллагсад зэрлэг үнэг болон шувуунд хоол унд тавьж өгөхгүй байх талаар анхааруулах.	Төслийн хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд багтсан	Ажилчдын тосгоноос гарч буй хоол үлдэгдэлийг зориулалтын цэг дээр булж устгах, зэрлэг амьтан нохой, шувуу тэжээхгүй байх зэрэг зааварчилгааг бүх аж ахуйн нэгжүүдийн ажилчдад тогтмол өгч хяналт тавин ажиллаж байна.
2	Мал амьтны гарцыг замын зураг төсөлд зурагдсаны дагуу хийж гүйцэтгэх	Төслийн хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд багтсан	Байгаль орчны үнэлгээний “Мон Газар Экологи” ХХК болон Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг /WCS/ - ийн зэрлэг амьтдын нүүдэл шилжилтийн тухай судалгаан дээр үндэслэн “Эй энд Би инженеринг” ХХК-ийн боловсруулсан мал, зэрлэг амьтны гарц гарам барьж байгуулах зураг төслийн дагуу хийж цүйцэтгэж байна.
3	Зэрлэг амьтны судалгааг мэргэжлийн байгууллагаар хийх эсвэл төрийн байгууллага бүс нутагт дэд бүтцийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллага болон байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтран хийж гүйцэтгэх	Бүс нутгийн хэмжээнд	Үйл ажиллагааны зардалд багтсан	
4	Биологийн олон янз байдлыг хамгаалах ажлын хүрээнд зэрлэг амьтадад зориулсан автомат ажиллагаатай уст цэгийг бий болгож хяналт мониторинг хийх камер суурилуулах	Өмнөговь аймгийн өгсөн зөвлөмжийн дагуу	Сонгон шалгаруулалтаар	2022 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд зэрлэг амьтанд зориулсан автомат худаг болон хөв цөөрөм байгуулах ажлын гэрээг 2022 оны 12 сарын 31 нд “Болор ус” ХХК-тай байгуулан урьдчилгаа төлбөр шилжүүлэн ажиллаж байна.




5	Биологийн олон янз байдлыг хамгаалах ажлын хүрээнд ан амьтныг хууль бусаар агнахтай холбоотой постер хийх	Өмнөговь аймгийн өгсөн зөвлөмжийн дагуу	Үйл ажиллагааны зардалд багтсан	Биологийн олон янз байдлыг хамгаалах ан амьтныг хууль бусаар агнах, эд эрхтэнийг зарах, тэжээх, гаршуулахаас сэргийлсэн постер хийж гүйцэтгэсэн.
---	---	---	---------------------------------	--

5.4.1 Мал амьтны гарцыг замын зураг төсөлд зурагдсаны дагуу хийж гүйцэтгэх Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн ачаа тээврийн авто замд төлөвлөсөн мал, амьтны гарц


Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто замд мал, амьтны гарцыг нийтдээ 21 цэгт 5х3 харьцаатай дөрвөлжин дан болон хос төмөр бетон хоолой төлөвлөсөн байна. Дан хоолойн урт 5м, харин хос хоолойн урт нь 10м, өндөр нь 3м хэмжээтэй болно. Дээрх 21 цэгийн мал амьтны гарцаас гадна мал амьтан гаргах боломжтой 2.5х2.0м дөрвөлжин хоолой 7 цэгт, /2.5х2.0/х2 дөрвөлжин хоолой 8 цэгт, /2.5х2.0/х3 дөрвөлжин хоолой 6 цэгт тус тус төлөвлөгдсөн байна.

Хүснэгт 7. Нүхэн гарцын байршил


Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн авто замын мал, амьтны гарцын байрлал					
Багцын дугаар, (урт)	Хэсгийн урт /м/	Хэсгийн дугаар	№	Туннелийн байрлал	Туннелийн овор хэмжээ
Lot-1 (77.5км)	50168.5058	II	1	8+151	/5.0х3.0/х2
			2	23+630	/5.0х3.0/х2
Lot-2 (101.13км)	45299.4457	III	3	1+980	/5.0х3.0/х2
			4	23+960	/5.0х3.0/х2
			5	24+700	/5.0х3.0/х2
			6	27+920	5.0х3.0
	55826.2137	IV	7	1+740	5.0х3.0
			8	5+500	5.0х3.0
			9	24+380	5.0х3.0
			10	36+340	5.0х3.0
Lot-3 (73.78км)	29999.6157	V	11	7+940	5.0х3.0
			12	26+940	5.0х3.0
	43781.0137	VI	13	4+365	5.0х3.0
			14	31+020	5.0х3.0
Lot-4 (94.0км)	52014.4937	VIII	15	42+428	/5.0х3.0/х2
			16	49+003	/5.0х3.0/х2
Lot-5 (76.1км)	25770.5094	IX	17	15+779	/5.0х3.0/х2
	50282.6789	X	18	33+930	/5.0х3.0/х2
Lot-6 (47.45км)	47415.543	XI	19	9+870	/5.0х3.0/х2
			20	26+244	/5.0х3.0/х2
			21	35+780	/5.0х3.0/х2




Зураг 24. Мал амьтны гарцын тойм зураг




Зураг 25. Авто замд төлөвлөсөн төмөр бетон хос хоолойн ерөнхий байдлыг



Зураг 26. Төмөр бетонон хоолойн хөндлөн огтлол



Зураг 27. Гарцын байршил



Зураг 28. Гарцны байршил /Үргэлжлэл/

5.4.2 Зэрлэг амьтны судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж гүйцэтгэх

Байгаль зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг (WCS)-ийн монгол дахь төлөөлөгчийн газраас ирүүлсэн судалгааны ажлын үр дүн

Үндэслэл шаардлага

Ханги – Тавантолгой чиглэлийн төмөр зам барих бүс нутагт Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах олон улсын конвенц (*Convention on Conservation of the Migratory species of Wild Animals, CMS*)-д бүртгэлтэй цагаан зээр (*Procapra gutturosa*), хар сүүлт (*Gazella subgutturosa*), хулан (*Equus hemionus*), аргаль (*Ovis ammon*) зэрэг амьтад байршдаг. Эдгээр туруутан амьтад нэг бэлчээр нутгаас нөгөөрүү байнга шилжин байрших замаар бэлчээр нутгийг хэт талхлахгүй байх буюу бэлчээрийг сэлгээтэй ашиглах байгалийн үндсэн хөдөлгөгч хүч болдог. Түүнчлэн үржил төллөх газар, ундаалах ус, идэш тэжээлийн эрэлт нь түүний уудам орон зайд шилжих нүүдлийн шалтгаан нь болдог. Иймд бүс нутагт 2013 болон 2015 онуудад хүзүүвч зүүсэн 40 хулангийн шилжилт хөдөлгөөний мэдээнд үндэслэн энэхүү ерөнхий зөвлөмжийг хүргэж байна.


Зөвлөмж, санал

Цагаан зээр, хулан, хар сүүлт, нь тухайн жилийн цаг агаарын нөхцөл, ургамлын гарц хүний болон байгалийн бусад хүчин зүйлээс хамааран харилцан адилгүй нүүдэл шилжилт хийдэг. Иймд Тавантолгой-Ханги чиглэлийн автозамын трассын дагуу газар нутгийн онцлог, зэрлэг амьтны нягтшилаас хамаарч 10-20 км тутамд ижил түвшний гарц байгуулах. Хулангийн шилжилт хөдөлгөөн авто замын трасстай давхцсан цэгүүдийг ижил түвшний гарц байгуулахдаа тооцож үзэх хэрэгтэй.


Хатуу хучилттай замын дагуух ус зайлуулах шуудуу, хамгаалалтын хашлага зэргийг аль болох бага хэмжээнд байлгах хэрэгтэй. Суваг шуудуу зайлшгүй хэрэгтэй тохиолдолд тэдгээрийг гүн ухахаас сэргийлэх

Зэрлэг амьтанд зориулсан гарц гармын ойролцоо амьтан зам хөндлөн гарч болзошгүйг сануулсан болон хурдны хязгаарыг анхааруулсан өдөр, шөнө аль ч үед харагдах тэмдэглэгээг суурилуулах. Засмал зам, түүгээр өнгөрөх тээврийн хөдөлгөөний эрчим нь тус нутагт тархсан шилжилт хөдөлгөөнд нөлөөлж буй эсэхийг байнгын мониторинг судалгаагаар тандах.

“Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу зэрлэг амьтад зориулсан гарц” MNS 6515 : 2015 стандартын дагуу тухайн бүс нутгийн газар зүйн байршил, газар нутгийн онцлогт тохируулан нэг түвшний гарцыг стандарт хэмжээсний дагуу байгуулах ажлыг шаардлагын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх зэрэг тус тус шаардлагатай байна.



Зураг 29. Автозамын трасс болон хулангийн шилжилт хөдөлгөөн байршилыг давхцуулсан байдал



Зураг 30. Автозамын трасс хүзүүвч зүүсэн хулангийн шилжилт хөдөлгөөнтэй огтлолцох байдал

5.4.3 Биологийн олон янз байдлыг хамгаалах ажлын хүрээнд зэрлэг амьтад зориулсан автомат ажиллагаатай уст цэгийг бий болгож хяналт мониторинг хийх камер суурилуулах

2022 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд зэрлэг амьтанд зориулсан автомат худаг болон хөв цөөрөм байгуулах ажлын гэрээг 2022 оны 12 сарын 31 нд “Болор ус” ХХК-тай байгуулан урьдчилгаа төлбөр шилжүүлэн ажиллаж байна.



Зураг 26. Автомат худаг, хөв цөөрөм байгуулах ажлын гэрээ

5.4.4 Биологийн олон янз байдлыг хамгаалах ажлын хүрээнд ан амьтныг хууль бусаар агнахтай холбоотой постер хийх

Биологийн олон янз байдлыг хамгаалах ан амьтныг хууль бусаар агнах, эд эрхтэнийг зарах, тэжээх, гаршуулахаас сэргийлсэн зурагт постер хийж гүйцэтгэсэн.



Зураг 27. Зэрлэг ан амьтан тэжээх гаршуулахыг хориглосон зурагт постер



Зураг 31. Зэрлэг амьтан хууль бусаар агнах, эд эрхтэнг худалдахыг хориглосон зурагт постер

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Зардалын хэмжээ мян.төг	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	Техникийн нөхөн сэргээлт	Түр кэмп буусан тохиолдолд хог хаягдлыг цэвэрлэн орон нутгийн холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгнө	Үйл ажиллагааны зардалд багтсан	Төслийн ажил дуусаагүй, тогтмол явагдаж байгаа тул орон нутагт хүлээлгэн өгөх ажилчдын тосгоны зориулалтаар ашигласан талбай байхгүй байна.
2	Техникийн нөхөн сэргээлт	Эзэнгүй орхигдсон 5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж Байгаль орчин аялал жуулчлалын газарт хүлээлгэн өгөх	Үйл ажиллагааны зардалд багтсан	Өмнөговь аймгийн Манлай сумын Далай багын нутагт орших “Ширүүн” нэртэй газарт “Баянмандал хошуу” ХХК-аар 5 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгүүлэн орон нутагт акт үйлдэн хүлээлгэн өгсөн. Өмнөговь аймгийн Манлай сумын Өгөөмөр багын нутагт орших “Хар булаг-Элгэн-Харганаг-Түймэрт” нэртэй газарт “Баянмандал хошуу” ХХК-аар 5 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгүүлэн орон нутагт акт үйлдэн хүлээлгэн өгсөн.
3	Техникийн нөхөн сэргээлт	Зам барилгын засвар арчилгаа хийх урт хугацаанд хүн амьдрахаар төлөвлөгдөх кемпийг тодруулж орчны тохижилтын зориулалтаар мод тарих тайлан мэдээ, төлөвлөгөөг харьяа орон нутагт илгээх	Дотоод төлөвлөлтөөр	Одоогоор ЛОТ тус бүр 25 ширхэг улиас, 22 ширхэг хайлаас модыг орчны тохижилт, ногоон байгууламж байгуулах зорилгоор тарьж ургуулсан байна.



4	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн	<p>Өмнөговь аймаг, Дорноговь аймгуудын байгаль орчны газраас үүрэг болгосон хуваарьт сумтай модны квот тоогоо авч гэрээ байгуулан тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд төлөвлөгөө боловсруулан ажлыг эхлүүлнэ.</p>	Үйл ажиллагааны зардалд багтсан	<p>Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд Дорноговь, Өмнөговь аймгуудтай модны гэрээ байгуулсан. Одоогоор замын бүтээн байгуулалт, тээвэртэй холбоотойгоор автозамын төслийн дагуу мод тариж ургуулах боломжгүй учир замын төсөл хэрэгжиж дуусах шатанд гэрээний дагуу төлөвлөгдсөн моднуудыг үе шаттай тарьж ургуулахаар төлөвлөн ажиллаж байна. Мөн 2022 онд тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд Дорноговь аймгийн Хатанбулаг суманд 10 сая төгрөгний модны суулгацыг хандивлах ажлыг зохион байгуулж ажилласан.</p>
---	-------------------------------	---	---------------------------------	--

6.1.1 Техникийн нөхөн сэргээлт

Байгаль орчныг хамгаалах, хүрээлэн буй орчныг нөхөн сэргээх асуудал нь байгаль орчны менежмент төлөвлөлтийн чухал нэг хэсэг юм. Аливаа хөндөгдсөн газар нутгийг нөхөн сэргээх, унаган ургамал тариалах үйл ажиллагаа нь тухайн бүс нутгийн экосистемийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг удаан хугацаанд хадгалах үндсэн суурь болдог. Иймд Өмнөговь аймгийн Манлай сумын Далай багын нутагт орших “Ширүүн” нэртэй газар, Өгөөмөр багын нутагт орших “Хар булаг-Элгэн-Харганаг-Түймэрт” нэртэй газарт хууль бус аргаар алт олборлолтонд өртөж эвдэрсэн газрыг нөхөн сэргээлтийн стандартын дагуу гүйцэтгэж “Баянмандал хошуу” ХХК-аар 5 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгүүлэн орон нутагт акт үйлдэн хүлээлгэн өгсөн.


Ажлын хэсэг хэрэгжилтийг 75% - тай дүгнэсэн. Иймд тухайн ажлын нөхөн сэргээлтэнд нэмэлтээр газрын гадаргын хэлбэржүүлэлт, буцаан дүүргэлтийн ажлыг стандартын дагуу гүйцэтгэх, гүйцэтгэлийн явцад хяналт тавих зөвшилцлийг гаргав.

Техникийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэхдээ хүчин төгөлдөр хэрэгжиж буй дараах стандартыг баримтлан ажиллана.

- ✓ MNS 5916 : 2008 - Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт , хадгалалт
- ✓ MNS 5917 : 2008 - Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага зэрэг болно.




Зураг 32. Нөхөн сэргээсэн талбайн ажлын шалгалт




Зураг 33. Манлай сумын Далай багийн Ширүүн нэртэй газрын нөхөн сэргээсэн талбай




Зураг 34. Манлай сумын Далай багийн Ширүүн нэртэй газрыг нөхөн сэргээсэн байдал




Зураг 35. Манлай сумын Өгөөмөр багийн Түймэрт нэртэй газрын нөхөн сэргээсэн талбай



Зураг 36. Манлай сумын Өгөөмөр багийн Элгэн-1 нэртэй газрын нөхөн сэргээсэн талбай



Зураг 37. Манлай сумын Өгөөмөр багийн Элгэн-2 нэртэй газрын нөхөн сэргээсэн талбай



Зураг 38. Манлай сумын Өгөөмөр багийн Элгэн-3 нэртэй газрын нөхөн сэргээсэн талбай



Зураг 39. Манлай сумын Өгөөмөр багийн Элгэн нэртэй газрыг нөхөн сэргээсэн байдал

6.1.2 Техникийн нөхөн сэргээлт

Төслийн үйл ажиллагааны үед зам барилгын ажил, засвар арчилгаа хийх түр болон урт хугацаанд хүн амьдрахаар төлөвлөгдсөн кемпүүдэд орчны тохижилт болон нөхөн сэргээлтийн зориулалтаар мод тарих ажлыг одоогоор ЛОТ тус бүр 25 ширхэг улиас, 22 ширхэг хайлаас модыг орчны тохижилт, ногоон байгууламж байгуулах зорилгоор тарьж ургуулж байна.



Зураг 40. ЛОТ-1 Ажилчдын кемп орчимд мод тарьж байгаа байдал



Зураг 41. ЛОТ-3 Ажилчдын кемп орчимд мод тарьж байгаа байдал



Зураг 42. ЛОТ-4-8 Ажилчдын кемп орчимд мод тарьж байгаа байдал





Зураг 43. ЛОТ-6 Ажилчдын кемп орчимд мод тарьж байгаа байдал

6.1.3 Тэрбум мод үндэсний хөдөлгөөн

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх тухай зарлигыг 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдөр гарагасан билээ. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн нь 2030 он гэхэд тэрбум мод тарьж, арчлан хамгаалж, ургуулснаар ойн санг 9%-д хүргэж, цөлжилт, газрын доройтлыг бууруулан, хүлэмжийн хийн шингээлт, усны нөөцийг нэмэгдүүлж уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж, ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлэх зорилготой.

Энэхүү “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Дорноговь, Өмнөговь аймгуудтай модны гэрээ байгуулсан. Одоогоор замын бүтээн байгуулалт, тээвэртэй холбоотойгоор автозамын төслийн дагуу мод тариж ургуулах боломжгүй учир замын төсөл хэрэгжиж дуусах шатанд гэрээний дагуу төлөвлөгдсөн моднуудыг үе шаттай тарьж ургуулахаар төлөвлөн ажиллаж байна. Мөн 2022 онд тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд Дорноговь аймгийн Хатанбулаг суманд 10 сая төгрөгний модны суулгацыг хандивлах ажлыг зохион байгуулж ажилласан.



Зураг 44. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарьж байгаа байдал



Зураг 45. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарьцыг хүлээлгэн өгөв

ДОЛОО. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Археологи, палентеологийн тайлангийн үр дүнд төсөл хэрэгжих талбайн орчимд түүх соёлын олдворын ул мөр байхгүй гэсэн дүгнэлт гарсан. Гэвч компанийн хэмжээнд түүх соёл, археологийн олдвор олдсон тохиолдолд хэрхэн ажиллах үеийн журам зааврыг боловсруулан компаний удирдлагаар батлуулж нийт ажиллагсад, шинээр тус компанид орж буй ажилтан бүрд зааварчилгаа мэдээллийг өгч ажиллаж байна.

НАЙМ. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

№	Болзошгүй аюул сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Зардалын хэмжээ мян.төг	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	Шатах тослох материал хөрсөнд асгаралт өгөх хөрс бохирдох улмаар усан орчинд нөлөөлөх	Нэвчих шингэх материалыг засварын талбайн ойролцоо байрлуулах, хөрсөнд ШТМ асгарсан тохиолдолд автобаазын хөрс саармагжуулах талбайруу бохирдсон хөрсийг зөөх	Төслийн нийт ажиллагсад	ШТМ -аар хөрс бохирдсон тохиолдолд тусгайлан бэлдсэн саармагжуулах талбайд бохирдсон хөрсийг шилжүүлэх зэргийг тухай бүрт зохион байгуулж ажиллах шаардлагыг тогтмол өгч ажиллаж байна. 2023 онд автозамын ажил эхлэх үед бүх туслан компаниудад хаягдал тос тослох материалтай ажиллах зааварчилгаа, сургалтыг өгч батлагдсан журмыг мөрдүүлж ажиллахаар төлөвлөж байна.
2		ШТМ-н асгаралтын үед ажиллах үеийн зааварчилгааг боловсруулж засварын хэсэг болон техникийн операторуудад танилцуулах		2022 оны 01 дүгээр сарын 02 нд “Ти Ти Си Ти” ХХК-ийн захиралын 2023/А-07 дугаар тушаалаар ШТМ-ын асгаралтын үеийн зааварчилгааны журам баталж 2023 оноос мөрдүүлэн ажиллахаар төлөвлөөд байна. Тайлангийн хавсралт хэсэгт батлагдсан журмыг хавсаргав.
3	Тоосжилт ихсэж ажилчдын эрүүл мэнд оршин суугчдад нөлөөлөх	Ажилчдад хор саармагжуулах бүтээгдэхүүн болон хөдөлмөр хамгааллын	Үйл ажиллагааны зардалд багтсан	Ажилчдын ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний дагуу ажилчдыг хор саармагжуулах бүтээгдэхүүн, хөдөлмөр хамгааллын хэрэгсэлээр бүрэн хангаж ажиллаж байна



		хувцас хэрэглэлийг бүрэн өмсүүлэх		
4	Ажилчид амьтан ургамалд хор хохирол учруулах /ан агнуур, ховор ургамлыг сүйтгэх, талхлах/	Нийт ажилчдын дотоод журманд тусгаж зааварчилгааг тухай бүр өгөх	Үйл ажиллагааны зардалд багтсан	Төслийн бүх ажилчдад зэрлэг ан амьтан агнах, үргээх, нүүдэл шилжилт хөдөлгөөнд саад хийхгүй байх, зөвшөөрөлгүйгээр олон салаа зам гаргах, хөрс, ургамлан бүрхэвчийг талхлахгүй байх зэрэг заавар зөвлөмжийг компанийн дотоод журманд тусган мөрдүүлж ажиллаж байна.

8.1.1 Шатах тослох материал хөрсөнд асгарах хөрс бохирдох улмаар усан орчинд нөлөөлөхөөс сэргийлэх

Шатах тослох материалаар хөрс бохирдсон тохиолдолд тусгайлан бэлдсэн саармагжуулах талбайд бохирдсон хөрсийг шилжүүлэх зэргийг тухай бүрт зохион байгуулж ажиллах шаардлагыг тогтмол өгч ажиллаж байна . 2023 онд автозамын ажил эхлэх үед бүх туслан компаниудад хаягдал тос тослох материалтай ажиллах зааварчилгаа, сургалтыг өгч батлагдсан журмыг мөрдүүлж ажиллахаар төлөвлөж байна.



Зураг 46. Шатах тослох материалын асгаралт хөрс, усанд шингэхээс сэргийлсэн байдал

8.1.2 Тоосжилт ихсэж ажилчдын эрүүл мэнд оршин суугчдад нөлөөлөхөөс сэргийлэх

Тоосонцрын ширхгийн голч нь 2.5 микроноос бага хэмжээтэй байвал нарийн ширхэглэгт тоосонцор буюу PM2.5, 10 микроноос түүнээс бага хэмжээтэй тоосыг том ширхэглэгт тоосонцор буюу PM10 гэж ангилдаг.

Тоосонцор нь хүний эрүүл мэндэд дараах сөрөг нөлөө үзүүлдэг :

- Хүний биед агаараас орсон тоос, мананцар, уур, давирхайлаг бодисын том ширхэгтэй нь эхлээд амьсгалын дээд замын эрхтэн хамар, төвөнх, цагаан мөгөөрсөн хоолойн үс, намираа хучуур эдэд баригдан дээрх эрхтэнүүд цэр, нустай хамт гадагш гаргадаг.
- Нарийн ширхэглэгт тоосонцор механик хольцууд нь хамар, төвөнх, гуурсан нь хоолойн салбарласан бүдүүн хэсгээр дамжин орж, уушгины цулцан гуурсан хоолойн нарийн хэсгүүдэд гүнзгий нэвтрэн орж, цулцангийн дотоод гадаргууг бүрхэн гэмтээж, уушги тоосжих өвчнийг үүсгэж уушгины дотоод гадаргуугийн талбайг багасгадаг.
- Мөн нарийн ширхэглэгт тоосонцрууд нь гуурсан хоолойн нарийн сүвүүдийг бөглөж, цулцанд орох хүчилтөрөгч бүхий цэвэр агаарыг саатуулж, уушги мөгөөрсөн хоолойн үрэвсэлт (уушгины хатгалгаа, бронхит гэх мэт) өвчнийг үүсгэн хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг.

Замын төсөлд ажиллаж буй ажилчдын ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, хөдөлмөрийн эрүүл ахуй, ажлын байранд эрдсийн тоосны өртөлтөөс ажилтныг хамгаалахад тавигдах ерөнхий шаардлага MNS 6658 : 2017 стандартын талаар мэдлэг мэдээлэл өгч, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний дагуу ажилчдын хорыг саармагжуулах бүтээгдэхүүн, хөдөлмөр хамгааллын хэрэгсэлээр бүрэн хангаж ажиллаж байна.

8.1.3 Ажилчид ан амьтан, ургамалд хор хохирол учруулахаас сэргийлэх

Замын төслийн туслан гүйцэтгэгч компаниудын ажилчид мэдлэг мэдээлэл, журам, зааварчилгааны талаар тодорхой мэдээлэлгүйн улмаас төслийн талбайд болон ойр орчимд нүүдэллэх ан амьтдыг агнах, үргээх, айлгаж чоцоох, хөөх ховор ургамлыг түүж бэлтгэх зэрэг асуудлыг гаргаж болзошгүй юм. Иймд үүнээс сэргийлэхийн тулд төслийн бүх ажилчидад зэрлэг ан амьтан агнах, үргээх нүүдэл шилжилт хөдөлгөөнд саад хийхгүй байх, зөвшөөрөлгүйгээр олон салаа зам гаргах, хөрс, ургамлан бүрхэвчийг талхлахгүй байх зэрэг заавар зөвлөмжийг компанийн дотоод журманд тусган мөрдүүлж ажиллаж байна.





Зураг 47. Ажилчидад хөдөлмөр хамгаалал болон тоосжилт, ан амьтан, ургамалд хор хохирол учруулахаас сэргийлэх талаар мэдээлэл өгч байгаа байдал

БС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

№	Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Зардалын хэмжээ мян.төг	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
Ахуйн хог хаягдал				
1	Хог хаягдлыг төрөлжүүлэн ангилан ялгах	Төслийн хэмжээнд	Дотоод төлөвлөлтөөр	Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгаж ажиллаж байна. Мөн түүнчлэн Эко Говь төслийн хүрээнд “Дэлгэрийн Дэрс” ХХК-тай дахивар хог хаягдал нийлүүлэх гэрээг 2023 оны 2 сарын 2 ны өдөр байгуулан хамтарч ажиллахаар төлөвлөөд байна.
2	Орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулан ажиллах.		Гэрээний дагуу	Бүх туслан компаниуд орон нутгийн нутагтай хог хаягдлын гэрээ байгуулсан. Хог хаягдлын төлбөр төлсөн баримтыг тайланд хавсралтаар оруулсан болно.
3	Хог хаягдлыг бүртгэлжүүлэн хэмжих мэдээллийг тухай бүр орон нутагт тайлагнах		Дотоод төлөвлөлтөөр	БОХ-3 маягтын дагуу хог хаягдлын мэдээг гаргаж орон нутагт илгээсэн.
4	Нийтээр цугларах газруудад хаяг шошготой хогийн сав байрлуулж аж ахуйн туслах буюу холбогдох ажилтан цуглуулж түр кемпийн нэгдсэн цэгт ангилж ачуулах	Төслийн түр кемпүүд болон хогийн цэг		Ангилан ялгах хогийн савыг шаардлагатай цэг бүрт байрлуулж ангилан ялгах ажлыг тогтмол хийж хэвшүүлж ажиллаж байна.
5	Үйл ажиллагаа явуулж буй газар нутгийн орчимд бүх нийтийн цэвэрлэгээг тогтмол зохион байгуулах	Төсөл хэрэгжиж буй талбайд 150-300 метрийн эргэн тойронд	Дотоод төлөвлөлтөөр	Бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг буугаагүй байгаа зарим кемпүүд дээр болон трассын зам дагуу зохион байгуулж ажиллаа.

6	Замын ажлын ажиллагсадын байрлах кэмпүүд дээр Орон нутгийн холбогдох зөвшөөрөл зөвлөмжийн дагуу хог хаягдлын түр цэг байгуулж цугларсан хог хаягдлыг орон нутгийн хог хаягдлын үйл ажиллагаа эрхлэгч ТӨҮГ-тай байгуулсан гэрээний дагуу тухайн байгууллагаас тээвэрлэлт, хог хаягдлын устгалын үйлчилгээ авах	Төслийн түр кэмпүүд	Дотоод төлөвлөлтөөр	Орон нутагтай байгуулсан хог хаягдлын гэрээний дагуу хамтарч ажиллаж байна.
7	Хог хаягдлын сав баглаа боодлыг эргүүлэн ашиглана. Тухайлбал хаягдал дугуйгаар замын тэмдэг тэмдэглэгээ хаалт хийх, хог хаягдлын түр цэгүүд дээр хашаа хаалт болгож ашиглах поошигоор техникийн тосгуур сав, хогийн сав хийх гэх мэт...	Төслийн хэмжээнд	Дотоод төлөвлөлтөөр	Хаягдал поошиг зэргийг хог хаягдлын ангилан ялгах сав болгон ашиглаж байна.
8	Хог хаягдлын тухай хуулийн 10.3.6-д ААНБ нь хөрс бохирдуулагч жорлон байгуулахыг хориглосон заалтыг хэрэгжүүлж стандартад нийцсэн тайлан ирүүлэх	Ахуйн септик танк цэвэрлэх байгууламжтай туслан гүйцэтгэгч	Дотоод төлөвлөлтөөр	Лот 6, Лот 1 зэрэг туслан компаниуд дээр септик танк байгуулсан. Цаашид бүх хэсгүүдийг нүхэн жорлонгоос татгалзаж байгальд ээлтэй эко 00 ашиглах ажлуудыг үе шаттай зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.
9	Хаягдал бохир усны стандарт MNS 4943:2015 мөрдөж ажиллах		Дотоод төлөвлөлтөөр	Хаягдал усыг саарал ус болгон зам талбай, ногоон байгууламжийн усалгаанд ашиглахаар боломжийг судлан ажиллаж байна.

10	Сумын байгаль хамгаалагчтай хамтран хог хаягдлын ангилан ялгалтын сав байршуулах, сургалт зохион байгуулах	Замын туслан кемпүүдийн хэмжээнд	Дотоод төлөвлөлтөөр	Өмнөговь аймгийн Цогтцэций, Манлай, Ханбогд Дорноговь аймгийн Хатанбулаг сумын замын төслийн туслан гүйцэтгэгч компаниудын ажилчидад хог хаягдлын тухай сургалтыг зохион байгуулж ажилласан.
----	--	----------------------------------	---------------------	--

9.1.1 Хог хаягдлыг ангилан ялгах

Хог хаягдлыг тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т заасны дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах, 15 дугаар зүйлийн 15.1-д заасны дагуу хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн хогийн савнуудыг кемпүүдэд байрлуулж мөн түүнчлэн Эко Говь төслийн хүрээнд “Дэлгэрийн Дэрс” ХХК-тай дахивар хог хаягдал нийлүүлэх гэрээг 2023 оны 2 сарын 2 ны өдөр байгуулан хамтарч ажиллахаар төлөвлөөд байна.



Зураг 48. Ангилан ялгах хогийн савнууд



Зураг 49. Ангилан ялгах, хог хаягдал салхиар хийсхээс сэргийлсэн хогын сав




Зураг 50. Тамхи татах цэг хогын сав

9.1.2 Орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулан ажиллах

Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.3-т заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах; 10.2.4-т заасны дагуу хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх заалтын дагуу “Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн хатуу хучилттай автозам байгуулах” төслийн хэсэг /ЛОТ-1, ЛОТ-2, ЛОТ-3, ЛОТ-4, ЛОТ-5, ЛОТ-6/ тус бүр тухайн сум болон аж ахуй нэгж байгууллагатай хог хаягдлын гэрээг байгуулсан.

		
ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ГЭРЭЭ		
2021 оны 08 сарын 09 өдөр	№ 2021/16	Цогтцэций сум
<p>Монгол Улсын Үндсэн хууль, Монгол улсын Хог хаягдлын тухай хуулийн 10.2.7, Зрүүл ахуйн тухай хууль, Өмнөговь аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны дугаар 9/8 тогтоол Өмнөговь аймгийн Засаг даргын 2019 оны А/1354 захирамж үндэслэн:</p> <p>Нэг талаас Цогтцэций сумын Засаг даргын тамгын газрыг төлөөлж Уул уурхай, ус хариуцсан Байгаль хамгаалагч Т. Бадамцаг,</p> <p>Нөгөө талаас Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 25 дугаар хороо, 13 хороолол, нарны зам, 167, 14 /РД-2767546, УБД-9011119066/ “Ундарга од” ХХК-ыг төлөөлж МАКД ХХК-ны орон нутаг хариуцсан менежер Б. Сүх-Эрдэнэ нар /хамтад нь талууд гэх/ харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.</p>		
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ		
<p>Энэхүү гэрээгээр ангийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.</p> <p>Энэхүү гэрээ нь 2021 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн 2021 оны 12 дугаар сар 31-ны өдрийг дуустал хүчин төгөлдөр байна.</p>		
1.1. Гэрээний бүрдэл: Гэрээний хавсралт		
1.2. Хамрах хүрээ: Цогтцэций сумын нутаг дэвсгэр		
ХОЁР. ЦОГТЦЭЦИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЭРХ, ҮҮРЭГ		
2.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах		
2.2. Хог хаягдлын талаар мэргэжил арга зүйн туслалцаа, зөвлөгөө өгөх.		
2.3. Хог хаягдлын түр цэгийн зөвшөөрөл олгох		
2.4. Хог хаягдлын түр цэгт хог булшлахгүй, ил задгай хаяхагүй байхад хяналт тавих.		
2.5. Эзэмшил газар, лицензийн талбай, хөмөл, ажигчдын суурин орчны хог хаягдал, цас мөсийг цэвэрлүүлэх, тухайн байгууллагын үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлыг цэвэрлүүлэх.		
2.6. Зориулалтын бус газар хог хаягдал зөвшөөрөлгүй хаясан, булшилсан, нуун дарагдуулсан тохиолдолд хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох.		
